



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 6 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 - 60

- 1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/* 7 - 32
- 2. Монгол Улсын олон талт олон улсын гэрээ, гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан сонсох* 32 - 58
- 3. “Сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл* 59 - 60

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 6 дугаар сарын 14-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 20 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: М.Оюунчимэг, С.Одонтуяа.

Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Монгол Улсын ерөнхий аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, Тэргүүлэх аудитор Я.Самбууням, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Б.Батжаргал, Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр, мэргэжилтэн Э.Цолмон, Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн Ж.Алтантуяа, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн Э.Цолмон, Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Лувсан, мөн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Д.Отгонбаатар нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Б.Жаргалмаа, С.Ганбаатар, Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл, Б.Бейсен нарын тавьсан асуултад Сангийн сайд

Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Б.Батжаргал, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын олон талт олон улсын гэрээ, гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүл бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, мөн яамны Гадаад хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлтсийн дарга З.Хүслэн, Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих хэлтсийн дарга Б.Алтантулга, Гадаад хэргийн яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд, мөн газрын атташе А.Баярсайхан, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, Хүний эрхийн Үндэсний Комиссын Гадаад хамтын ажиллагааны тасгийн дарга Ө.Ундрах, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч Т.Мөнгөнцэцэг, Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Гэр бүл, эмэгтэйчүүдийн хөгжлийн асуудал хариуцсан ахлах шинжээч Ч.Эрдэнэчимэг, мөн газрын Хүүхдийн эрхийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Азжаргал, Хүүхдийн хөгжил, оролцооны асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Бат-Эрдэнэ, Гэр бүл, эмэгтэйчүүдийн хамгааллын бодлого, зохицуулалт хариуцсан шинжээч Р.Нарантуяа, Гадаад хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлтсийн Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээ, конвенц, хэлэлцээр хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Нямсүвд, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль тогтоомж, нийгмийн оролцоо хариуцсан мэргэжилтэн Б.Болороо нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Д.Отгонбаатар нар байлцав.

Монгол Улсын олон талт олон улсын гэрээ, гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Б.Жаргалмаа, Д.Батлут, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын олон талт олон улсын гэрээ, гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

“Сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга П.Анужин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно.

П.Анужин: “Сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 34 минут үргэлжилж, 17 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 88.2 хувийн ирцтэйгээр 13 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

П.АНУЖИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр,

Лхагва гараг

Төрийн ордны “Их эзэн Чингис хаан”

танхим

11 цаг 20 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

П.Анужин: Байнгын хороодынхоо гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52.9 хувьтай бүрдсэн тул Байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Д.Батлут гишүүн ирсэн байна. С.Ганбаатар гишүүн ирсэн байна, Б.Жаргалмаа гишүүн ирсэн байна, Ц.Мөнх-Оргил гишүүн ирсэн байна, Ц.Сандаг-Очир гишүүн, Ц.Туваан гишүүн, С.Чинзориг гишүүн, Ц.Идэрбат нарын гишүүд хуралдаанд хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэндээ танилцуулъя.

Нэгдүгээрт, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бид хэлэлцэнэ.

Түүний дараагаар Монгол Улсын олон талт олон улсын гэрээ, гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг бид сонсоно.

Түүний дараа “Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой Хяналтын сонсголын тов сонсох, сонсгол даргалагчийг томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батална.

Өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбоотойгоор өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй. Хэлэлцэх асуудалдаа орё.

Төсвийн тодотголын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлнэ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Та бүхэндээ танилцуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай.

Байгаль орчны байнгын хороон дээр танилцуулж байгаа юм. Орж ирж байна. Ажлын хэсгийн гишүүд өөр Байнгын хороон дээр танилцуулгаа хийгээд дуусаад удахгүй орж ирэх гэж байгаа учраас Байнгын хорооны гишүүд түр хүлээж байгаарай.

Төсвийн ажлын хэсгийн гишүүд харахан дуусаагүй учраас Байнгын хорооны гишүүдийн саналаар хэлэлцэх асуудлынхаа дараагийн асуудалд орж байя.

Ц.Мөнх-Оргил гишүүн хүрэлцэн ирсэн байна. Монгол Улсын олон талт олон улсын гэрээ, гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг сонсоно.

Хууль зүйн байнгын хорооноос 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор Монгол Улсын олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийг хянан шалгах ажлын хэсгийг Цэндийн Мөнх-Оргил гишүүнээр ахлуулан байгуулсан.

Энэ хүрээнд олон талт олон улсын 30 гэрээний үүргийн хэрэгжилтийг хянан шалгасан бөгөөд гэрээний үүргийн биелэлтийг хангуулахад тодорхой чиглэл шийдвэрийг Засгийн газарт өгөхөөр ажиллаж байгаа.

Нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 18 олон талт олон улсын гэрээ байгаа.

Ажлын хэсгийн ахлагч Цэндийн Мөнх-Оргил гишүүнийг танилцуулгаа хийхийг урьж байна.

Ажлын хэсгийнхэн ирсэн байгаа. Тийм. Ажлын хэсгийн гишүүдийн нэрийг. Хоёр дээр байгаа юу. Тийм ээ. Хэлэлцэх асуудлын хоёрдугаартай холбоотой хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүл бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гадаад хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлтсийн дарга З.Хүслэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих хэлтсийн дарга Б.Алтантулга, тус яамны Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч Т.Мөнгөнцэцэг, тус яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Гэр бүл, эмэгтэйчүүдийн

хөгжлийн асуудал хариуцсан ахлах шинжээч Ч.Эрдэнэчимэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүүхдийн эрхийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Азжаргал, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Дангаагийн Баярболд, Гадаад хэргийн яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд, Хүний эрхийн Үндэсний Комиссын Гадаад хамтын ажиллагааны тасгийн дарга Ө.Ундрах, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүүхдийн хөгжил, оролцооны асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Бат-Эрдэнэ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гадаад хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлтсийн Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээ, конвенц, хэлэлцээр хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Нямсүвд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль тогтоомж, нийгмийн оролцоо хариуцсан мэргэжилтэн Б.Болороо, тус яамны Гэр бүл бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Гэр бүл, эмэгтэйчүүдийн хамгааллын бодлого, зохицуулалт хариуцсан шинжээч Р.Нарантуяа, Гадаад хэргийн яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын атташе А.Баярсайхан гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Цэндийн Мөнх-Оргил гишүүнийг танилцуулгаа хийхийг микрофонд урьж байна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа.

Байнгын хорооны гишүүд ээ, гишүүдэд ажлын хэсгээс Байнгын

хорооноос ийм гурван том презентаци, слайдууд тараасан байгаа.

Нэг нь 48 хуудастай. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлийн.

Төсөв ороод ир лээ дээ. Төсвөө хэлэлцүүлчих үү? Дарга аа. Тэгье тэгэх үү?

Дараагийн Байнгын хороо нь яачих байх. Тэгье. Учлаарай.

**Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн
2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд**
*/Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ
Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/*

П.Анужин: Асуудлыг түр хойшлуулаад Төсвийн байнгын хороо бас дараагийн Байнгын хороодод танилцуулга хийж хэлэлцүүлэх ёстой учраас асуудлынхаа нэгдүгээрт эргэж оръё.

Ажлын хэсгийн гишүүдийг Та бүхэндээ танилцуулъя.

Ажлын ажлын хэсгийн гишүүд орж ирсэн байна уу? Оруулаад ирээрэй.

Сангийн сайд Болдын Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа, Монгол Улсын ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат, Сангийн дэд сайд Санжаагийн Мөнгөнчимэг, Монгол Улсын ерөнхий аудиторовын орлогч албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цэвэгсүрэнгийн Наранчимэг.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулж ирээрэй. Танхимд.

Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ядамын Самбууням, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын

захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого төлөвлөлтийн газрын дарга Амарсайханы Хишигбаяр, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн Э.Цолмон, тус яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн Ж.Алтантуяа, тус яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн Э.Цолмон, Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын

газрын дарга Лхагважавын Лувсан, Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ламжавын Бямбасүрэн гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Төсвийн тодотголын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Та бүхэндээ танилцуулсан.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хороон дарга, эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас экспортыг эрчимжүүлж гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд эдийн засаг 2023 оны 1 дүгээр улиралд 7.9 хувиар өсөж, гадаад валютын албан нөөц энэ оны эхний 5 сарын байдлаар 3.8 тэрбум долларт хүрч сайжраад байна.

Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр инфляц төдийлөн буурахгүй, иргэдийн бодит орлогод нөлөөлж байгаа тул ард иргэдийн орлого, амьжиргааг дэмжих зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Дээр дурдсан эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын Засгийн газраас иргэдийнхээ орлогын баталгаа, амьдрах орчныг сайжруулах, хотын түгжрэлийг

бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгалаа. Тухайлбал,

1.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрт олгохын зэрэгцээ хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд нөхөж олгох;

2.Тэтгэврийн зөрүүний асуудлыг цалингийн суурь итгэлцүүрийг шинэчлэх замаар шийдвэрлэх, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх;

3.Төрийн албаны цалингийн тогтолцоог шинэчилж, суурь цалингийн хэмжээг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын сүлжээг өргөтгөх зэргээр нийслэлийн түгжрэлийг бууруулах арга хэмжээг төсөв хооронд зохицуулалт хийж шийдвэрлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгаад байна.

Төсвийн тодотголын арга хэмжээний үр дүн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1.7 их наяд төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлага 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдэх бөгөөд нэгдсэн төсвийн нийт алдагдал 1.6 их наяд төгрөг буюу анх батлагдсан дотоодын нийт бүтээгдэхүүний 2.6 хувиас хэтрүүлэхгүй байхаар төсөвлөлөө.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Анужин: Сангийн сайд Болдын Жавхланд баярлалаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Д.Занданбат танилцуулна.

Д.Занданбат дарга ирээгүй байгаа юм байна. Орлогч Ц.Наранчимэг дарга танилцуулах уу? 1 номерын микрофоныг өгье.

Ц.Наранчимэг: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу төрийн аудитын байгууллагаас дараах дүгнэлтийг гаргаж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 20 их наяд 781.9 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34.5 хувь, нийт зарлагын хэмжээг 22 их наяд 371.4 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37.2 хувь, төсвийн алдагдлыг 1 их наяд 589.5 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2.6 хувь байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт дараах өөрчлөлтүүдийг оруулсан байна.

Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын төсөв 2023 оны батлагдсан төсвөөс 520.4 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн сайдын төсөв 56.6 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн төсөв 405.5 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 122.1 тэрбум буюу нийт дүнгээр 1.1 наяд төгрөгөөр тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв нэмэгдсэн байна.

Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын урсгал зардлын төсөв нийт 520.4 тэрбум төгрөгөөр өссөн нь Төрийн албан хаагчдын цалингийн шинэчлэлд 30.3 тэрбум төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нөхөх болон хүсэлт гаргасан бүх хүүхдэд олгохоор 167.2 тэрбум төгрөг, тэтгэврийн зөрүүг арилгаж, инфляцын түвшинтэй уялдуулж нэмэгдүүлснээр төрөөс хариуцах тэтгэврийн зардалд 229.2 тэрбум төгрөг, зарим нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хувь хэмжээг өсгөхөд 89.8 тэрбум төгрөг, бусад үйл ажиллагаанд 3.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмж төлөвлөсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн батлагдсан төсвийн нийт зардал 405.5 тэрбум төгрөгөөр өсөхөд өндөр насны тэтгэврийн зөрүүг арилгах, тэтгэврийн хэмжээг инфляцтай уялдуулж 10 хувиар нэмэгдүүлэхэд 389.8 тэрбум төгрөг, төрийн албан хаагчдын цалингийн шинэчлэлт 10.1 тэрбум төгрөг, бусад үйл ажиллагаанд 5.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлсөн байна.

Зардлын эх үүсвэрийг нийгмийн даатгалын санд төлөх, төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотой 206.7 тэрбум төгрөг, төр хариуцах иргэдийн тэтгэврийг 229.2

тэрбум төгрөгийн шимтгэлийн орлогоос тус тус бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оныг батлагдсан төсвийн зарлага 1 их наяд 603.5 тэрбум төгрөг болж, 1 их наяд 481.4 тэрбумаар нэмж тооцсон сангаа олгох зарим тусламж, үйлчилгээний санхүүжилтийн тарифыг нэмэгдүүлэхээр төлөвлөсөнтэй холбоотой байна.

Зардлын эх үүсвэрийг нийгмийн даатгалын санд төлөх төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотой 97 тэрбум төгрөг, эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх арга хэмжээнд олгох улсын төсвийн урсгал шилжүүлгээс 25.1 тэрбум төгрөгийг тус тус бүрдүүлэхээр тооцсон байна.

Эрүүл мэндийн сайдын батлагдсан төсвийн зардлыг 56.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсний 29.2 тэрбум төгрөг нь эмч, эмнэлгийн ажиллагсдын цалингийн сүлжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой шаардагдах эх үүсвэрийг нэмж тусгасан байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлсийг нэмэгдүүлэхэд нийт зарлагын дийлэнхийг төлүүлж байгаа нь иргэдийн амьжиргааг дэмжих эерэг талтай байна гэж үзлээ.

Төрийн аудитын байгууллага 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна гэж дүгнэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

П.Анужин: Баярлалаа. Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Байнгын хорооны гишүүд Та бүхэндээ хүргэсэн байгаа.

Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Содномын Чинзориг, Буланы Бейсен гишүүнээр асуулт асуух гишүүдийн нэрсийг тасалж байна.

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Төсвийн тодотгол хийж зөвхөн салбар ч гэлтгүй Монгол Улс даяар төрийн албан хаагчдын цалинг нэмэх гэж байгаа явдал маш таатай сайхан, шударга ёс тогтож, төсөв өөрөө нэмэх гарч байгаа явдалд Их Хурлын гишүүдэд таатай байгаа.

Хэд хэдэн тодруулж асуух зүйл байна. Тухайлах юм бол Сангийн сайд, Эрүүл мэндийн сайд хоёулаа байгаа учир төсвийн хэмнэлтийн хуультай холбоотойгоор аймаг, дүүргүүдийн эрүүл мэндийн газруудын санхүүжилт асар их хумигдсан, санхүүжилт нь бараг 50 хувиар хасагдсан.

Тэр утгаараа гол нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байсан эрүүл мэндийн газруудын үйл ажиллагаа, яг нийтийн эрүүл мэндийн чиглэлд үйл ажиллагаа асар хязгаарлалтад орж байгаа.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор Та бүхэн. Бид яах вэ юун дээр ярих байх гэж бодож байна. Нөгөө хэмнэлтийн хуулийн

дагаж орсон хуулийн өөрчлөлт дээр бид үүнийг ярих байх. Гэхдээ энэ дээр Та бүхэн бодлоо нэг хэлээчээ.

Хоёр дахь асуудал нь, бид эрүүл мэндийн салбарын үр дүнгийн санхүүжилттэй холбоотойгоор цалин хөлс, урамшууллын тогтолцоо маш сайн бий болсон.

Үүгээрээ ч дамжаад 30-аас 70 хувь хүртэл цалин хөлс нэмэгдсэн. Зарим улсууд эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин ийм бага байж байгаад одоо л нэмэх гэж байгаа юм байна гэдэг нийгэмд нэг ийм ойлголт яваад байна.

Тийм учраас С.Чинзориг сайд энэ дээр анхаарч, мэдээллүүдийг нэлээн тийм тодорхой болгож тавьж өгөхгүй бол эрүүл мэндийн салбарынхан чинь ерөөсөө их бага цалинтай байсан юм байна гэдэг ойлголт төрчхөөд байдаг.

Гэлээ гэхдээ үндсэн цалин нэмэх асуудал өөрөө их чухал байна.

Тийм учраас үйлчилгээний ажилтнуудын үндсэн цалин яг хэдээс хэдэн төгрөг болох вэ?

Тэр дотроо эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй хамааралгүй эмнэлгүүд ч гэдэг юм уу, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг газрууд.

Та хүртэл хэлдэг. Зоонозын төв энэ тэр гээд. Цалин нэмэгддэггүй.

Тэр газруудын ажилчдын цалин яг хэдэн төгрөгөөр нэмэгдэх вэ? Энэ тоог нь та хэлж өгөөчээ?

Орон нутгаар яваад иргэдтэй, эрүүл мэндийн салбарын ажилчидтай уулзахад ер нь л хамгийн гол зорьж байгаа зүйл үндсэн цалинг нэмж өгөөч ээ.

Үндсэн цалин нэмэгдвэл бид нарын бусад үндсэн цалингаас дагагдаж бодох илүү цаг, урамшуулал, бүх юм нэмэгдээд бодогдчихно.

Тийм учраас үндсэн цалин яг бодитой хэд болох гээд байна вэ гэдгийг хэлж өгөөч ээ гээд байгаа.

Тэгэхээр та Эрүүл мэндийн яамнаас барьж байгаа бодлогын хувьд үндсэн цалинг яг доод суурь хэмжээ хэдээс хэд хүртэл нь өгч байгаа, нэмэгдүүлж байгаа гэдгийг тодорхой тоо баримтаар хэлж өгөхгүй юу.

Тэгээд төгсгөлд нь нэг зүйл асуух гэсэн юм.

Манай алслагдсан хороо болох Гачууртын эмнэлгийг бид буулгаад төсөвт шинэ эмнэлэг барихаар төсөвт суулгачихсан. 2022 онд ажил нь эхлээд явж байгаад 2023 онд төсөв нь байхгүй болчихсон.

Тэгээд хэний буруу нь мэдэгдэхгүйгээр ажил нь бүр ингээд зогсчихсон. 20 гаруй мянган иргэд эмнэлгийн анхан шатын тусламж, үйлчилгээ авах боломжгүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ дээр Сангийн яам ч байж байна, Эрүүл мэндийн яам ч байж байна. Энэ дээр нэг гаргалгыг нь хэлж өгөөч ээ.

Төсөвт ажил нь тусчихсан явж байсан ажил байхгүй болоод, одоо ямар ч санхүүжилт орох боломжгүй болчихоод байгаа байхгүй юу.

Энэ асуудлыг яах ёстой вэ?

П.Анужин: Асуултад Сангийн сайд Болдын Жавхлан хариулья.

4 номерын микрофоныг өгөөрэй ажлын хэсгийн гишүүн хариулна өөрийгөө танилцуулаад асуултад хариулаарай.

2 номерын микрофоныг өгөөрэй. Өөрийгөө танилцуулаад асуултад хариулья.

Ж.Дэлгэржаргал: Ж.Чинбүрэн гишүүний асуултад хариулья.

Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал.

Гачууртын эмнэлгийн хувьд 20-той эмнэлгийн барилгыг 2022 оны төсөвт шинээр эхлүүлэхээр тавьсан.

Бид 2023 оны төсөв боловсруулахдаа 9 сарын 28-ны байдлаар гэрээ байгуулаагүй төслүүдийг хэмнэлтийн бодлогын хүрээнд 2023 оны санхүүжилтийг нь хасаж 2023 оны төсвийг өргөн барьсан.

Ингээд өргөн барьсны дараа санхүүжилт нь 2023 оны төсөв дээр тусгагдаагүй байхад 2022 оныхоо төсвийн хүрээнд Эрүүл мэндийн яам гэрээ байгуулсан гэсэн үг.

Тэгэхээр 2022 оны төсвийг нь бид гэрээ байгуулсан ажлынх нь хүрээнд Засгийн газрын тогтоолын хүрээнд барьцаа хөрөнгийн дансанд авчихсан байгаа.

Хэрвээ энэ төслийг яг 2024 оны төсөв дээр тусгагдах юм бол барьцаа хөрөнгийн санхүүжилтийг олгоод үргэлжлүүлээд явна.

Одоо барьцаа хөрөнгийн дансан дээр байгаа санхүүжилтийг чөлөөлж болохгүй байгаа шалтгаан нь энэ төслийг дуусгах, үлдэгдэл санхүүжилт нь шийдвэрлэгдээгүй байгаа учраас барьцаа хөрөнгийн дансанд чөлөөлөгдөөгүй байгаа.

П.Анужин: Ж.Чинбүрэн гишүүн дараа нь тодруулаад асуугаарай. Ж.Чинбүрэн гишүүний асуултад С.Чинзориг сайд хариулья.

С.Чинзориг: Төсвийн тодотгол зөвхөн цалингийн нэмэгдэлтэй холбоотой хийж байгаа учраас төсөвт байгууллагуудын урсгал зардалтай холбоотой, үйл ажиллагааны зардалтай холбоотойгоор тодотгол мөнгө тусгагдаагүй.

Ер нь цаашдаа бид эрүүл мэндийн бодлогодоо тогтолцооны өөрчлөлт хийх ёстой гэж бодоод байгаа юм.

Ер нь эрүүл мэндийг хамгаалах асуудал хоёр талтай. Бид тэр эмнэлгийн тусламж, үйлчилгээний асуудалд нь нэлээн их анхаарал хандуулж ирсэн. Нийгмийн эрүүл мэндийн асуудлыг нэлээн орхигдуулчихсан юм байна.

Тэгээд бид ирэх долоо хоногт Засгийн газарт Нийгмийн эрүүл мэндийн тусламж жуулчлалын тухай хууль өргөн барьж оруулах гэж байна. Энэ бусад орнууд ч гэсэн хөрөнгө санхүүгийнхээ 50-иас 60 хувийг нийгмийн эрүүл мэнд, анхан шатны тусламж, үйлчилгээнд үзүүлдэг.

Манайх хөрөнгө санхүүгийнхээ 19 хувийг л нийгмийн эрүүл мэнд, анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулж байгаа гэсэн судалгаа байгаа.

Тэгэхээр энэ чиглэлд өөрчлөлт орох болов уу гэж бодож байгаа.

Хоёр дахь асуудал нь, цалинтай холбоотой асуудал дээр нийтлэг төрийн үйлчилгээ доод тал нь 750 мянган төгрөг болж байгаа юм. Дээд тал нь сая төгрөг болж байгаа.

Нийтлэг үйлчилгээнийх нь. Нөгөө бага албан тушаалын үйлчилгээний ажилчид.

ТҮ буюу манай мэргэжлийн салбарынхан хамгийн доод цалин нь сая, дээд тал нь 2 сая 200 мянган төгрөг болох гэсэн тооцоо байгаа. Энэ бол доод жишиг шүү дээ.

Тэгээд манайх тэр үндсэн цалингийн доод жишиг. Тэгээд манайх нөгөө гүйцэтгэлийнхээ санхүүжилт авдаг.

Тэгээд тэр хүрээндээ бид энэ төсөв батлагдчихвал тарифтаа өөрчлөлт оруулаад, гүйцэтгэлийнхээ санхүүжилтэд олгох энэ тарифтаа цалингийн нэмэгдлийг нь тооцсон өөрчлөлт хийж цалингийн нэмэгдлийг олгох арга хэмжээг авна.

Нөгөө талдаа бидний яриад байдаг нөгөө алслагдсан сумдтай холбоотой асуудлууд ч гэсэн бас тэр тарифын газар зүйн коэффициент орно гэсэн ийм чиглэлээр ажиллаж байна.

Сүүлийн хоёр жил бид гүйцэтгэлийн санхүүжилтийг ашиглаж байсан. Гэхдээ энэ бүрэн утгаараа гүйцэтгэлийн санхүүжилтийг ашиглаад яг бодитой дүгнэлт хийчих тийм боломж би бүрдэхгүй байна гэж үзэж байна.

Яагаад вэ гэхээр КОВИД-ын нөхцөл байдлын улмаас бид чинь КОВИД-ын санхүүжилт гээд бас нэлээн

нэмэлт санхүүжилт төсвөөс шууд өгч ирсэн. Хоёр жилд.

Тийм учраас 2023 онд яг энэ гүйцэтгэлийн санхүүжилт бие даагаад санхүүжилтээр хэрэгжих учраас яг болж байна уу, бүрэн болж байна уу, болохгүй байна уу гэдэг нь үнэнтэйгээ нүүр тулах он нь бол би 2023 он гэж бодож байгаа.

Өмнөх жилүүдэд энэ гүйцэтгэлийн санхүүжилтийн үр дүнгээр цалинг өсгөхдөө манай дээр цалин хөлснийхөө бүтцийг жаахан тийм өөрчилчихсэн юмнууд байгаа юм байна лээ.

Ялангуяа цалин нэмэгдүүлэхдээ үндсэн цалин нэмэгдүүлэхгүйгээр ихэнх эмнэлгүүд дээр урамшууллын хэмжээг нэлээн нэмэгдүүлээд явсан асуудлууд байна.

Тийм учраас би энэ цалин хөлснийхөө бүтцэд жаахан өөрчлөлт оруулах, ялангуяа урамшууллын хэмжээг нь тод зохих хэмжээгээр бууруулж, үндсэн цалинг нь нэмэгдүүлэх чиглэлээр цалингийн нэмэгдлийг өөрчлөх нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа.

Тэр Гачуурт тосгонтой холбоотой асуудал. Х.Булгантуяа сайд, Гачуурт тосгоны дарга надтай уулзсан.

Манайхны надад өгсөн мэдээллээр мөнгийг нь манайх энэ жил аваад хоцорчихсон юм байна гэж би ойлгосон.

Тийм учраас гүйцэтгэгчийг нь сонгон шалгаруулаад явахад мөнгө нь манайд аваад үлдчихсэн юм байна.

Санхүүжилтийн хувьд асуудалгүй л гэж манай хөрөнгө оруулалтынхан надад мэдээлэл өгсөн. Үүнийгээ бид тодруулж байгаад шийдэх боломжтой болов уу гэж л бодож байна.

П.Анужин: Х.Булгантуяа гишүүн нэмэлт хариулт өгөх үү? Х.Булгантуяа сайд нэмэлт хариулт өгье.

Х.Булгантуяа: Манай тухайн хорооны Засаг дарга н.Гомбосүрэн дарга манай С.Чинзориг сайдтай очиж уулзсан юм.

Энэ яг ийм асуудал үүссэн юм байна лээ. Тэгээд энэ дээр манай яг үнэнийг хэлэхэд Эрүүл мэндийн яамныхан их хэнэггүй хандсаны одоо яг л үр дүн гарч байгаа байхгүй юу.

Тухайн хорооны эмнэлгийг нь ингээд буулгачихсан. Түр хорооны Засаг даргынхаа нэг давхарт бараг үйл ажиллагаа явуулж байгаа.

Тэгсэн мөртлөө 2023 оны төсвөөс маш олон хөрөнгө оруулалтуудыг хасахдаа 5 сая төгрөг ч хамаагүй, 50 сая төгрөг ч хамаагүй тавьж үлдээгүйгээс үүдээд 2022 оных нь төсвийн гүйцэтгэлийнх нь мөнгийг өгөхгүй.

Одоо ингээд тэр компани нь бараг 400-гаад сая төгрөгийн ажлаа хийчихсэн. 2022 он дээр төсөв дээр нь мөнгө байсан мөртлөө тэр санхүүжилтээ авч чадахгүй байгаа юм.

Тэгээд 2023 он дээр ямар ч төсөв тавигдаагүй учраас төсвийн тухай хууль зөрчөөд байна. Аудит дараа нь дүгнэлт энэ дээр акт тавьчихна гээд санхүүжилтийг нь гаргахгүй. Нөгөө компани нь ч хохироод, манай манай хороо ч хохироод. Ингээд 2024 оныг хүлээлтэл нөгөө компани нэг жоохон ажил хийчхээд 400 сая төгрөг авч чадахгүй ингээд л сууж байгаа юм.

Тэгэхээр уг нь энэ чинь мэргэжлийн яам яах гэж байгаа билээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 2023 онд төсөв дээр үнэнийг хэлэхэд эрүүл мэндийн салбарт нэг их олон хөрөнгө оруулалт толгой эргэхээр олон юм байхгүй байгаа шүү дээ.

Тэгэхэд тухайн үед манай Ж.Чинбүрэн гишүүн энэ тэрд байдаг юм уу, эсвэл бид нарт хандаад та нар 5 сая төгрөг ч байдаг юм уу, 50 сая төгрөг ч байдаг юм уу тавиад энэ төсвийнх нь санхүүжилтийг нь төслийг нь үргэлжлүүлэх эрх зүйн орчныг нь бий болгож өгөөд энэ компаниас санхүүжилтээ авах боломжийг нь нээгээд өгчхөөч ээ гээд нэг зөвлөчих л ёстой байсан.

Тэгээд одоо салбарын яамны энэ юунаас болоод энэ хэнэггүй, анхааралгүй, энэ салбарынхаа нэг хэдхэн хөрөнгө оруулалт ач холбогдол ч анхаарч чаддаггүйгээс болоод манай Гачуурт тосгон эмнэлэггүй болчихоод байж байгаа юм.

Үүнийг С.Чинзориг сайд, эсхүл Засгийн газар дээр тогтоол ороод юу яах ёстой юм уу, яах ёстой юм. Нэг л байдлаар л үүнийг шийдмээр байх юм.

Тэгээд энэ бүхэл бүтэн нэг хорооны, ядаж Гачуурт чинь хол шүү дээ. Та бүхэн мэдэж байгаа. Голцуу ахмадууд очоод тэнд тэтгэвэртээ гардаг. Жоохон хүүхдүүд ч ихтэй ийм тосгон байж байдаг. Тэгээд тосгоны эмнэлэг байхгүй. 2024 оныг хүлээгээд суугаад байдаг. Дунд нь нэг компани бас хохироод суугаад байдаг.

Тэгээд юмны үнэ, инфляцад нөгөө компанийнх нь 400 сая төгрөг нь

идэгдээд хэдэн төгрөг гэж болж байгаа юм. Ийм байж болмооргүй байх юм.

Энэ уг нь гишүүдийн асуудал биш байхгүй юу. Энэ салбарын яамны томоохон хөрөнгө оруулалтын асуудал.

П.Анужин: Ж.Чинбүрэн гишүүн хариулт хангалттай гэж үзлээ. Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууя.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өглөөний амгаланг айлтгая.

Төсөв батлагдаж тодорхой хэмжээнд цалин тэтгэвэр, халамжийн мөнгө өсөж байгаад үнэхээр талархалтай байгаа.

Энэ дээр нэг тодруулах зүйл байгаа. Нөгөө хүсэлт гаргасан хүүхэд бүрт гэдэг дээр олон нийт маань өөрсдөө саналаа илэрхийлсээр байгаа.

Өөрөөр хэлэх юм дахиад заавал өргөдөл өгөх юм уу, үгүй юү гэдэг дээр. Энэ дээр маш их бухимдал байгаа. Дахин дахин бараг гурав дахиа хүсэлт тавих гэж байгаа шүү гэдэг. Энэ дээр тайлбар өгөөч ээ.

Ижил цалин хөлсөөр ойролцоо хугацаанд ажиллан шимтгэл төлсөн боловч тэтгэвэр тогтоолгосон хугацаанаасаа хамаарч хоорондоо зөрүүтэй тэтгэвэр авч байгаа 164.6 мянган өндөр насны тэтгэврийн зөрүүг нь арилгана гэж тооцсон байгаа.

Тэгэхээр энэ дээр дэлгэрэнгүй тайлбар өгөхгүй бол мэдээллийн зөрүүтэй байдал гэдэг юм уу, бас ингээд нэг энэ орооцолдсон тайлбараас шалтгаалаад иргэд олон нийт буруу мэдээлэл аваад түүндээ бухимдах байдал үүсдэг.

Миний дахин дахин талархал илэрхийлж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнээ асарч байгаа, хүүхдээ асарч байгаа, эцэг эхээ асарч байгаа асаргааны мөнгө тодорхой хэмжээнд нэмэгдэж байгаа. Дунджаар 325 мянган төгрөгт хүрсэн, 275 мянгад хүрсэн ийм таатай мэдээлэл байгаа.

Тэгэхээр энэ дээр орхигдчихсон юмнууд байх шиг санагдаад байгаа юм. Бид хэд зөв буруу мэдэхгүй. Гэхдээ үүнийг оруулаасай гэдэг хүсэлтээ хэлэх гээд байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол бид Нийгмийн бодлогын байнгын хороо Хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв дээр очиж ажиллахад насанд хүрсэн хүүхдүүд тэнд байсан.

Тэр хүүхдүүд ямар нэгэн тэтгэмж авах боломжгүй байна гэдэг зүйлийг хэлж байсан. Өнөөдөр хуучин 3 ихрийн сувилал гэж ярьдаг байсан. Эцэг эхдээ хаягдсан, гэгдсэн, гологдсон хүүхдүүд халамж аваад байж байгаа.

Эдгээр хүүхдүүд энэ асаргааны тэтгэмжид хамрагдах уу?

Өөрөөр хэлэх юм бол нөгөө хүүхэд 3 ихрийн сувилал гэж байсан. Одоо Хүүхдийн төв сувилал гэдэг нэртэй байгаа юм байна.

Эдгээр хүүхдүүдийг хамруулах аваас эдгээр хүүхдүүдэд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээ, халамжаа төр тодорхой хэмжээнд нэмэгдүүлэх бүрэн боломж байгаа.

Нөгөө талаар Батсүмбэрдэх асрамжийн газарт байгаа ахмадуудын халамж төр ер нь яадаг юм бэ гэдэг зүйлийг би тодруулж байсан. Энэ мэт

хүмүүс орхигдох вий гэдэг зүйлийг асуух гэсэн юм.

Хоёрдугаарт нь, Төрийн албаны тухай хуульд бид өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа. Өөрөөр хэлэх юм бол хорооны Засаг дарга нар, хэсгийн ахлагч нарын цалинг нэмнэ гэсэн ойлголттой байгаа. Энэ дээр дахиад тайлбар өгөөч?

Баг, сумын Засаг дарга нарын цалин нэмэгдэнэ гэсэн. Энэ дээр хорооны засаг дарга, хэсгийн ахлагч нар орох уу, үгүй юү?

Төсөв хоорондын зохицуулалтаар түгжрэлийг сааруулах нийтийн тээврийг сайжруулах талаар бид энэ төсвийн тодотголоор тодорхой хэмжээний мөнгө оруулж байна.

Бид нийслэлийн түгжрэлийг сааруулахын тулд, авто замыг нэмэгдүүлэхийн тулд тодорхой хэмжээний санхүүжилтийг нийслэлдээ өгдөг болсон байгаа. Үүнтэй холбогдуулаад нийтийн тээврийн хүч нэмэгдүүлэх ийм ажил хийгдсэн. Гэхдээ өнөөдрийг хүртэл.

Би уг нь яг л үүнийг танхимд асууж байсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үүсэх тэр боломжит бүхий автобуснуудыг оруулж ирээрэй тэврээ оруулж ирээрэй гэхэд Төмөртөмөө дарга оруулалт ирсэн энэ үйлчилнэ ээ гэдэг мэдээллийг өгч байсан.

Гэтэл өнөөдөр шинээр орж ирсэн автобуснууд маань тэргэнцэртэй иргэдээ үйлчлэх боломжгүй, тэргэнцэртэй иргэд маань үйлчлүүлэх хүндрэлтэй. Эргээд иргэд олон нийт маань өргөж оруулсан ийм л байдалтай байгаа.

Тэгэхээр тодорхой хэмжээнд зориулж байгаа зориулсан шиг зориулаад

ийм зориулалтын нийтийн тээврийг оруулж ирмээр байна.

Бид нийгмээс хэн нэгнийг тусгаарлах ялгаварлах ийм эрх бидэнд байхгүй. Болж өгвөл бид саадгүй үйлчилгээг үзүүлэх ёстой гэдгийг аль аль төсөв мөнгө барьж байгаа улс ч тэр хөрөнгө оруулалт хийж байгаа улсууд ч гэсэн ойлгож байгаа байх.

Тэгээд энэ дээр тайлбар авъя. Яг энэ дээр ямар ажил хийгдэж байгаа вэ? Энэ гурван асуултдаа хариулт авчхаад дахиад тодруулж асууя.

П.Анужин: Б.Жаргалмаа гишүүний асуултад хэн хариулах вэ?

Ажлын хэсгийн гишүүд. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд Х.Булгантуяа хариулъя.

Х.Булгантуяа: Нэн түрүүнд бид ямар ч байсан эхлээд хүүхдийнхээ мөнгийг нэмж батлуулаад 100 хувьдаа ч гэсэн олгохоор хэмжээний мөнгөө төсвөөрөө батлуулчихъя. Яагаад гэвэл энэ батлагдахгүй байгаа цагт бид ямар байдлаар зарлага хийх боломжгүй. Төсвийнхөө тухай хуулийн дагуу.

Тэгэхээр ямар ч байсан эхлээд батлуулчихъя. Журмыг бид дараа нь Засгийн газраар орж батлуулдаг байж байгаа. Энэ дээр хүсэлт гаргасан гэдгийг хэрхэн яаж зохион байгуулах вэ гэдэг дээр иргэдээс ирж байгаа саналыг ойлгож байна.

Тухайн үед Валютын сангийн хөтөлбөр, Монгол Улсын зээлжих зэрэглэл буурах гээд байна. Эдийн засаг хүнд байна, хил хэзээ нээгдэх нь тодорхойгүй байна гэдэг чинь хил нээгдээд 6 сар л болж байгаа байхгүй юу.

Тэгэхээр ийм нөхцөл байдлаас үүдээд ингээд хасаад орж ирж байсан. Улсын Их Хурал ч гэсэн тухайн үедээ тэгж баталж өгч байсан. Тэгээд үүнтэй холбоотой эдийн засгийн үр нөлөөний талаар Б.Жавхлан сайдад илүү нэмж хариулах байх.

Тэтгэврийн зөрүүгийн хувьд энэ нөгөө бид нарын хувьд энэ тэтгэврийн зөрүү яагаад бид ингээд иргэд ч ойлгомжгүй, Улсын Их Хурал дээр бид ч гэсэндээ олон гишүүд маань сүүлийн хэчнээн жил сонсоогүй юм бэ гэхээр 2014 оноос хойш бид тэтгэврийн зөрүүг арилгахыг хийгээгүй байхгүй юу. Сүүлийн бараг 10 жил.

Тэгэхээр энэ бол уг нь жил болгон Засгийн газар батлаад нийгмийн даатгалын багц хууль өргөн барьчихсан. Нийгмийн бодлогын байнгын хороон дээр явж байгаа. Манай нийгмийн даатгалын багц хууль дээр жил болгон итгэлцүүрийг Засгийн газар батална.

Жил болгон итгэлцүүрээр тэтгэвэр нэмэгддэг болно гээд ингэчихвэл энэ жил болгон тэтгэврийн зөрүү гэдэг асуудлууд үүсэхгүй яваад байх ийм боломжтой.

Түрүүн хэлсэнчлэн тэтгэврийн зөрүү ямар хүмүүс дээр үүсээд байна вэ гэхээр нөгөө олон жилийн өмнө тэтгэвэр тогтоолгосон, одоо ахмадуудын маань дунд маш их бухимдалтай байгаа нь би одоо яг л адилхан ажил хөдөлмөр эрхэлж байсан.

Тэгсэн мөртлөө хоёр жилийн өмнө тэтгэвэрт гарч байгаа хүн 20 жилийн өмнө тэтгэвэрт гарсан бид хоёрын хооронд асар их зөрүү байгаад байна гээд.

Яагаад гэвэл 20 жилийн өмнө тэтгэвэрт гарсан хүний тэтгэврийг 2014

онд итгэлцүүрээр бодоод таны тухайн үед 20 жилийн өмнө тэтгэвэрт гарсан таны тэтгэвэр 2014 онд таны цалин үүнтэй дүйцэхүйц юм байна. Үүнээс чинь тэтгэвэр бодлоо гэхээр 10 жилийн хугацаанд юмны өмнө өсөөд, дундаж цалин ч өсөөд ингээд тэгэхээр итгэлцүүрээр бид нэмж дахиж бодохоос өөр аргагүй болчхоод байгаа юм. Тэгээд энэ эрт хойно гарсан. Нэгдүгээрт,

Хоёрдугаарт, 2022 онд тэтгэвэр нэмэхэд бараг ахмадын маань 20 хувь нь тэтгэврийн доод хэмжээг хэмжээнд нэмэгдэж орж ирсэн. Хуучин 50 орчим 50 гаруй хувь нь тэтгэврийн доод хэмжээгээр буюу тухайн үед 350 мянган төгрөгийн тэтгэвэртэй байсан бол 500 мянган төгрөгийн тэтгэвэртэй болоод ингээд ахмадуудын дунд бухимдал үүсчихсэн байж байгаа.

Үүнтэй холбоотойгоор манай Нийгмийн даатгалын ерөнхий газрын бид веб сайт дээр иргэд өөрснөө ороод овог нэрээ регистрийн дугаартайгаа ингээд оруулахад тэтгэврийн зөрүүг нь ингээд тооцоод өгчихдөг тоон мэдээлэл нь харагддаг байхаар бид оруулж байгаа.

Үүн дээр ер нь өндөр нийгмийн даатгалын шимтгэл төлсөн олон жил ажилласан хүмүүсийн тэтгэвэр тэтгэврийн зөрүүгөөр нэлээдгүй нэмэгдэхээр байж байгаа.

Насанд хүрсэн хүмүүст олгогдож байгаа юу? Одоо нөгөө хүүхэд хамгааллын тө төвүүдэд байгаа хүүхэд асрамжийн төвүүд дээр гээд Нийслэлийн Засаг даргад Засгийн газраас чиглэл өгөөд.

Энэ хэсгийн ахлагч нарын хувьд ингэж байгаа. Хороодын Засаг дарга нар төрийн албан хаагчид учраас нэмэгдэж орж ирж байгаа. Улс төрийн албан

тушаалтнууд гээд нэмэгдэж орж ирж байгаа. Багийн Засаг дарга нараас авхуулаад хорооны засаг дарга нар гээд ингээд нэмэгдэж байгаа.

Хэсгийн ахлагч нарын хувьд энэ нөгөө нийслэл цалинжуулдаг. Манай аймаг орон нутгуудаас ч гэсэн зарим аймгууд хэсгийн ахлагчтай, зарим аймгууд нь байхгүй байдаг.

Тэгэхээр үүнийг бид нөгөө улсын төсөв дээр сугалах боломжгүй. Улсын төсөв батлагдсаны дараагаар дагалдаад аймаг орон нутгууд төсвийн тодотголоо хийнэ. Орлого тал нь ч гэсэн нэмэгдэж байгаа. Цалин нэмэгдэж байгаа учраас.

Тэгэхээр үүнд бид Нийслэлийн Засаг даргад Засгийн газраас хэсгийн ахлагч нарын урамшууллыг зохистойгоор нэмэгдүүлэх гэдэг ийм чиглэлийг өгөөд явж байгаа.

П.Анужин: Хүүхдийн мөнгөтэй холбоотой асуултыг Сангийн сайд Б.Жавхлан сайд нэмж хариулья.

Б.Жавхлан: Б.Жаргалмаа гишүүний асуулт дээр нэмж хариулья.

Хүүхдийн мөнгийг бид хүсэлт гаргасан хүүхэд бүрд олгоё гэж шийдэж байгаа маань нэлээн өмнөх шийдвэр дээрээ том өөрчлөлт шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр тэр хүсэлт гаргана гэдгийг аль болох хүндрэл багатайгаар чирэгдэл байхгүйгээр шийдэх л ийм л хэрэгтэй байгаа юм.

Тэгээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллынхантайгаа ярилцаж байгаад бид ер нь нэг ийм шийдэл буюу хүмүүст нэг сонголтыг нь л хангах гээд байгаа юм. Хүүхдийн мөнгө авах шаардлагагүй

нэг хэсэг байгаа. Авахгүй гэсэн саналтай хүмүүс нэлээн байгаа байхгүй юу. Үүнийгээ хүүхдийн төлөвлөгөө фондод хандивлая ч гэдэг юм уу тэр хүмүүст боломжийг нь өгөх, сонголтыг нь өгөх хэрэгтэй. Тийшээгээ би хандивламаар байна гэдэг сонголтоо л дарахад бол оо. Тийм хүсэлт гаргаагүй бол хүүхдийн мөнгө авъя гэж байгаа юм байна гэж тооцоод л тийшээ хүүхдийн мөнгө нь очно гэсэн үг.

Одоо хэрвээ тийм ухаалаг байдлаар аппликэйшнаар ч юм уу тийм санал авах шийдэл явж байгаа. Тэгээд хэрвээ тийм цахим орчинд саналаа өгөх боломжгүй тийм хүүхдүүд, гэр бүл байвал санал нь очоогүй нь авна гэж байгаа юм байна гэж тэр хэсэгтээ ороод л хүүхдийн мөнгийг нь аваад явна гэсэн үг байхгүй юу. Тийм.

Авахгүй ээ. Тийшээгээ би хандивлая гэж байгаа хүмүүст нь сонголтыг нь л өгье. Тийм.

П.Анужин: Нөгөө насанд хүрсэн хүүхдүүдийн халамжийн асуудал байгаад байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн. Хэдэн номер вэ? 3 номерын микрофонд А.Хишигбаяр дарга хариулья.

А.Хишигбаяр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүрэг түр орлон гүйцэтгэгч, Бодлого төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр. БЖаргалмаа гишүүний асуултад хариулья. Х

Хламжийн сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж байгаа. 12.8 хувийг буюу 288 мянгаас 325 мянга нэмэгдүүлж байгаа.

Тэгэхээр насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний тухайд энэ халамжийн тэтгэвэр авдаг байгаа.

Тэгэхээр энэ хүмүүс тэтгэвэртээ хамрагдаад явж байгаа. Халамжийн сангаас нийтдээ 65 мянган хүн тэтгэвэр авдаг. Үүний 56 мянга нь 18-аас дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамрагдаж байгаа.

Тэгэхээр энэ хүмүүсийн тэтгэвэр 12.8 хувиар нэмэгдэж байна гэсэн үг. Харин насанд хүрээгүй хүүхэд болон насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүн хүүхэд асарч байгаа хүмүүст олгож байгаа асаргааны тэтгэмжийг нэмэгдүүлж байгаа. Насанд хүрсэн хүн асарч байгаа бол 84 мянга 500 авч байгаа. Хүүхэд асарч байгаа тохиолдолд 23 мянга 100 төгрөг авч байгаа. Энэ хоёр ялгаатай байгаа.

Энэ төсвийн тодотголоор үүнийг наснаас үл хамааран хүүхэд ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй хүн асарч байгаа бол 275 мянган төгрөг олгоно гэж төсвийн тодотголд оруулж байгаа.

Тэгэхээр энэ нэмэгдэж байгаа. Аль аль талдаа.

П.Анужин: Түгжрэлийн асуудалтай холбоотой асуултыг асуусан. Хэн хариулах вэ? Сангийн яам хариулъя. Тийм ээ. Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Тийм. Энэ удаагийн төсвийн тодотгол 5 зүйл дээр гол төвлөрч байгаа

Нэгдүгээрт, цалин, тэтгэвэр, одоо яг зорилгот халамж, хүүхдийн мөнгө. Ингээд нийслэлээ ч орхилгүй. Түгжрэлийн асуудал байгаа.

Түгжрэл дээр тавигдсан 187 тэрбум төгрөг ийм байгаа шүү. Нийслэлийн гишүүд маань тэр мэдээлэлтэй байгаа болов уу гэж найдаж байна.

Өнгөрсөн жил 420 тэрбум төгрөгөөр нийтдээ 22 төсөл санхүүжүүлнэ гэж авсан. Ерөнхийдөө 22 хэсэг буюу 11 ерөнхий төсөл байгаа.

Тэндээс гүйцэтгэл нь өнгөрсөн жил 233. Ингээд цаана нь 187 тэрбум төгрөгийн санхүүжилт үлдсэн. Тэрийг нь энэ жил гүйцээж өнгөрсөн жилийн ажлууд санхүүжилтээ аваад дуусах ёстой байгаа юм.

П.Анужин: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Ингээд ерөнхийдөө төсвийн тодотгол ярьж байгаа.

Тэгээд төсвийн тодотгол дээр яах вэ Сангийн яамны сайд Б.Жавхлантай холбогдож хэлэхэд үнэхээр энэ цалин нэмж байгаа, төрийн албан хаагчдын цалин нэмж байгаа. Одоо энэ Х.Булгантуяа сайд байна. Энэ нийгмийн халамж, энэ тэтгэвэр нэмж байгаа явдал үнэхээр чухал зүйл.

Би үүнийг дэмжиж байгаа.

Хамгийн гол нь энэ дээр байнга би асуугаад байгаа юм гэвэл үүнийгээ буцааж идүүлэхгүйн тулд хэдүүлээ яах вэ гэдгээ л яриад байгаа юм шүү.

Энэ бүр хуруу хумсаа маажиж байж л энэ нэмж байгаа юу? Нэмэхгүй бол ер нь төрд ажиллах хүнгүй болчихоод байгаа шүү дээ. Ялангуяа баг, сум, хороон дээр хүнд байгаа. Нэмэхээс өөр аргагүй.

Зүгээр миний бүтэн долоо хоног би яриад байгаа үндсэн санаагаа хэлэхэд гадаад худалдааны бодлого тэг, гадаад харилцааны бодлого уначихсан. Үйлдвэрлэлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн бодлого, мөнгөний бодлого, татварын бодлого, боловсролын бодлого, тендерийн бодлого, зээлийн бодлого. 12 том бодлого байдаг. Энэ макро эдийн засагт.

Ганцхан төсвийн бодлогоор л бид ингэж явуулаад ингээд ухантаад байна гэдэг өөрөө буцаад энэ нэг жоохон нэмсэн юмнаасаа гурав дахин илүү их нөгөө цалин, тэтгэврийг нь буцаагаад алгадчих вий гэдгээр л би байнга.

Тэгээд миний асуулт тодорхой асуулт байна шүү дээ. Ийм ийм байна.

Нэгдүгээрт, яах вэ би саяын ярьсан зүйлээ тодруулъя гэвэл цалинг ингээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр 36 хувиар нэмэгдэж байгаа юм байна. 78 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ.

Нэмэгдэл нь 20 тэрбумаар нэмэгдэж байгаа. Нийгмийн даатгал төлөх шимтгэл 2 тэрбумаар нэмэгдэж байгаа юм байна. 9.6 тэрбумаар нэмэгдээд. 37.9 хувь.

Энэ нэмэгдлүүдийн хөлд чирэгдээд адил төстэй хувийн хэвшлийнхэн цалингаа нэмэхгүй бол болохгүй. Нэмэхээрээ зэрэг тэр зарж байгаа талхан дээрээ нэмэх үү? Өөр ямар арга зам байгаа вэ? Олон улсад гадаад худалдааны зах зээлээ ярьдаг, бүтээмжээ ярьдаг.

Манайд яг ямар бодлого байгаа вэ? Энэ чинь одоо энэ хүмүүсийг 36 хувиар энэ дүрмийн сангийг нь

цалингийн санг нэмснээрээ хувийн хэвшил дээр өнөөдөр энэ ачаалал ирнэ. Тэрийг л би тодруулж байгаа.

Хоёрдугаарт, энэ Хөдөлмөрийн яаман дээр 78 тэрбум төгрөг гэж байгаа.

Хамгийн гол том гурван том энэ хэдэн хүнд вэ ямар ямар байгууллага вэ? Нөгөө нийгмийн даатгал байна уу, яг хэдэн хүн байна тэрийг бидэнд нэг тодорхой хэлээд өгөөч.

Ер нь олон улсад ингээд хүмүүсийн цалин нэмэх шаардлагатай төрийн албан хаагчдыг нэмэх шаардлагатай гээд тэрийгээ орон сууцын хөтөлбөр янз бүрийн нийгмийн асуудалтайгаа их холбож ярьдаг.

Ялангуяа хятадууд багш нарын орон сууцын хөтөлбөр гээд тусдаа хөтөлбөр байдаг.

Цалин нэмэх гэхээр нөгөө нөгөө хувийн хэвшилдээ дарамт болчих гээд инфляцдаа өртөгдчих гээд байдаг учраас бусад бодлогуудаараа дэмждэг ийм аргууд байдаг. Энэ дээр бид ажиллахгүй бол болохгүй байна. Нарийн яривал инфляцын татвар гэж ярьдаг юмны үнэ өссөн. Татвар мэдээж нэмэгдэж байгаа.

Тэгээд миний дараагийн тодруулах асуулт, хоёр дахь асуулт. Эрүүл мэндийн яаман дээр бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамж гээд 606 хувь нэмэгдсэн байгаа. Тэр бол данс хооронд шилжүүлсэн байх аа. Бараа, үйлчилгээний бусад зардал гэдгээ шилжүүлсэн байна гэж би харж байна. Үүнийг би тодруулъя.

2.4 тэрбум байж байгаад одоо энэ 17 тэрбум болсон.

Тэгэхээр доор нь бараа, үйлчилгээний бусад зардал гээд.../минут дуусав/

П.Анужин: С.Ганбаатар гишүүний асуултад Сангийн сайд Болдын Жавхлан хариулья.

Б.Жавхлан: Тийм ээ.

Энэ удаагийн төсвийн тодотголоор бид тэтгэвэр, тэтгэмж халамж гээд яг иргэдийнхээ эдийн засгийн аюулгүй байдал, өрхийн орлогыг дэмжиж байгаа юм.

Сүүлийн 3 жилийн хугацаанд бид КОВИД, дайн тулаан гээд төсөв маань нэлээн хүндхэн чанга явж ирлээ. Өнгөрсөн жил өдийд бүр Монгол Улс маань дефолт орох уу, үгүй юу гэдэг тэр ирмэг дээрээ байсан.

Ингээд эдийн засгийг либералчлах богино хугацаанд шат дараатай арга хэмжээнүүд амжилттай үр дүнд өгсний үр өнөөдөр бид энэ төсвөө үндсэн тэнцэл маань эерэг гарч ингэх үү тодотгол хийх боломж гарч ирж байгаа юм.

Өөрөөр хэлбэл бид хамгийн эхний боломж гарсан энэ цаг мөчид ард иргэдийнхээ өрхийн орлого, энэ бүхнийг нэмж байна гэсэн үг.

Хэрвээ бид энэ инфляц болон бусад макро тэнцлээ хараад ингээд хүлээх юм бол хагас жил, бүтэн жил дахиад ч хүлээж магадгүй. Яг тэр болтол таны түрүүн хэлсэн нөхцөл байдал үүнийг тэсэж хүлээж чадахгүй.

Төрийн албан хаагч нараа бид Солонгос руу алдаад дуусах юм байна.

Дээрээс нь бид төрийн үйлчилгээгээ ч явуулж чадахгүй тасалдах

эрсдэл үүснэ. Юун хагас жил хүлээх вэ, бүтэн жил хүлээх вэ. Ийм сонголт дээр л өнөөдөр бид энэ шийдвэрийг гаргаж байгаа байхгүй юу.

Харин тэглээ гээд энэ инфляцыг тавиад туучихгүй. Засгийн газар, Монголбанк бид гараа үмхээд суухгүй. Мэдээж үүнийг сарниулах бүхий л боломжит арга хэмжээгээ авна.

Мөнгөний бодлогын хувьд мэдээж зөөлрүүлэх ийм орон зай ойрын хугацаанд гарахгүй. Тэгээд ядаж энэ түвшиндээ байна.

Бараа, бүтээгдэхүүний хувьд нийлүүлэлт талаас нь, тээвэр ложистикийн талаас нь, энэ хилийн нэвтрэн өнгөрүүлэх чадвар, зохиомлоор үнэ өсгөх, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гээд бүх боломжоороо бид энэ үнийн өсөлтийг хязгаарлах ямар л боломж байна, эдийн засгийн аргаар, захиргаадлын аргаар бүхий л фронт дээр Засгийн газар ч ажиллана, Монголбанк ч ажиллаад явна. Тийм.

П.Анужин: С.Ганбаатар гишүүн тодруулья.

С.Ганбаатар: Өчигдөр би Сонгинохайрхан дээр уулзалт хийлээ.

Би хэдий Орхон аймгаас сонгогдсон ч гэсэндээ Монгол Улсын гишүүн шүү дээ.

Тэгээд аймгуудаар дүүргүүдээр явж уулзалт хийнэ. Тэгэхэд Заяа гээд доктор байна. Манай үйлдвэрчинд Боловсролын үйлдвэрчний холбоонд хамт ажиллаж байсан доктор маань уулзаад 150, 161 мянган тэтгэвэр авагчидтай холбоотой нэг юм ярьсан.

Тэгээд энэ дээр миний энэ тэтгэврийн тал дээрх үл ойлголцол их байна. Яг яаж нэмэгдэх юм бэ гээд. Хүүхдийн мөнгө авах гээд очихлоор л их хүндрэл гарч байна. Хандивлах уу гээд өөдөөс дарамтлаад байна гэсэн маягийн юм ярьж байсан. Би нэр устай нь энд авсан юм шүү. Хаягаар нь.

Тэгэхээр тэтгэвэр, цалин, хүүхдийн мөнгөтэй холбоотой энэ үл ойлголцол гомдол маргаантай холбоотой зүйл дээр хэнээс би асуух вэ? Ямар утсаар би хандах вэ? Надад нэг утас хэлж өгөөч, эзэн би нэр хэлж өгөөч гэдгийг.../минут дуусав/

П.Анужин: 3 номерын микрофонд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам А.Хишигбаяр дарга хариулья.

А.Хишигбаяр: С.Ганбаатар гишүүний асуултад хариулья.

Өнөөдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хүрээнд 5230 хүн ажиллаж байгаа. Үүнээс нийгмийн даатгалын байгууллагад 1577, хөдөлмөр халамж үйлчилгээний салбарт 1765 хүн ажиллаж байгаа.

Цалингийн нэмэгдэл энэ салбарын ажилчдын цалингийн нэмэгдэл болон нийгмийн даатгалын шимтгэл төсөв дээр нэмэгдэж харагдаж байгаа. Түрүүнийх.

Хүүхдийн мөнгөний асуудал дээр e-halamj, e-mongolia дээр хүүхдийн мөнгөний хүсэлтүүдийг авахаар бэлтгэл ажлаа хийж байгаа.

Асуултуудын хувьд манайд шууд утсууд бүгд ажиллаж байгаа.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. 1289, 77771224 гэсэн утсууд

ажиллаж байгаа. 77771224, 1289 гэсэн утсанд ажиллаж байгаа.

П.Анужин: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Х.Булгантуяа сайд Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо ер нь энэ төсвийн тодотгол, цалин мөнгө нэмэгдүүлэх тал дээр ямар байр суурьтай байгаа вэ? Сэтгэл ханамж хэр байгаа вэ?

Өнгөрсөн нэг, хоёр жилийн хугацаанд нэлээд олон жагсаал цуглаан, шаардлага юмнуудыг хүргүүлж байсан. Салбар салбарын ажилтны цалинг нэмэгдүүл гэж.

Тэгээд үндсэндээ энэ тодотголоор тавьж байсан шаардлагууд тодорхой хэмжээнд биелж байна гэж ойлгож байна.

Тэгэхээр Та бүхэн энэ дээр ерөнхийдөө энэ үйлдвэрчинтэй яаж уялдаж энэ тодотгол дээр санал хүсэлтийг нь авсан юмнууд нь юу байна. Цаана нь тавьсан шаардлагаас нь ороогүй зүйлүүд юу байна гэдгийг нэгд хариулж өгөөч ээ.

Хоёрт, энэ тодотгол дагасан хэд хэдэн тогтоол гарч байгаагийн нэг нь энэ “Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар” гэснийг “Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын ерөнхий газар” гэж өөрчилж байгаа юм байна. Бүтцийн хувьд өөрчлөлт орж байгаа юм байна.

Энэ тогтоолыг дагаад холбогдох хуульд яаж өөрчлөлт орж байгаа вэ?

Хоёрт, аймаг, нийслэл, дүүргийн энэ бүтцийн байгууллагууд дээр бүтэц орох уу, хийгдэх үү? Ер нь зарчмын хувьд үйл ажиллагааны үндсэн чиглэл нь яаж хоёр хуваагдаж байгаа юм.

Залуучууд нь тусдаа болж байгаа юм байна гэж би хувьдаа харж байна.

Тэгэхээр гэр бүл голцуу тэр хамгаалалт тал руугаа үйл ажиллагааны үндсэн чиглэл нь явах юм байна гэж ингэж харж байна.

Тэгээд энэ дээр дагаад ямар томоохон өөрчлөлтүүд хийгдэхээр байна вэ гэдгийг хоёрт асууя.

Гуравт, би Нийгмийн даатгалын ерөнхий газраас хүн байгаа юу? Ерөнхий газраас.

Би Нийгмийн даатгалын ерөнхий газраас. Бас сайд нь байна. Тодорхой асуулт асууя.

Танай яамны сайдын тушаалаар 2020, 2021 оны нийгмийн даатгалын тэтгэвэр тогтоолтод улсын үзлэг шалгалт хийгдсэн юм байна. Улсын хэмжээнд.

Энд тухайлбал, Багануур дүүрэгт гэхэд 120 орчим хүмүүсийн зөрчил илэрсэн юм байна. Ахмадуудын тэтгэвэр тогтоолт. Ажиллаагүй жилээ ажилласан жил болгож хуурамчаар нотлох баримт бүрдүүлж шүүх дээр тэтгэвэр тогтоолтоо хийлгээд энэ нь нийгмийн даатгалын улсын байцаагч энд нь акт тогтоогоод ингээд өнгөрсөн 2 жилийн хугацаанд ахмадуудын тэтгэврийг зогсоочихсон.

Гэтэл тэр ахмадууд өнөөдрийг хүртэл 2 гаруй жилийн хугацаанд нэг ч орлогогүй явж байна.

Өнөөдөр тэдний дундаас бараг 10 орчим ахмадууд нас барчихсан байна. 30 орчим хүмүүс болохоор өөрсдийнхөө алдаа бурууг хүлээн зөвшөөрөөд тэтгэвэрээ 50 хувийг нь нийгмийн даатгалын санд учруулсан хохирол 2 тэрбум төгрөг нийтдээ яригдаж байгаа

юм байна. Өөрсдийнхөө учруулсан хохирлыг 50 хувийг нь төлөөд 50 хувийг нь тэтгэвэрээ аваад явж байгаа ойлголцоод явж байгаа асуудал байна.

30, 40 гаруй хүмүүс нь энэ алдаа зөрчлөө хүлээн зөвшөөрөхгүйгээр ерөөсөө нийгмийн даатгалын улсын байцаагч, шүүгчийн гаргасан шийдвэрийг даатгалын байцаагч хүчингүй болгосон нь буруу гээд заргалдаад ингээд явж байгаа.

Өчигдрөөс уржигдраас дүүрэг дээр суулт зарлаад явж байгаа. Энэ 30, 40 ахмадууд. Цаашдаа улс төрийн дараагийн тэмцэлд орно гээд явж байх жишээтэй.

Энэ дээр Та бүхэн Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ямар байр суурьтай байгаа юм. Дандаа ядуу зүдүү, орлого муутай, ахмадуудад чиглэсэн ийм хүмүүс хамрагдаад явж байна.

Тэр буруу тогтоосон асуудал нь цагдаа дээр хэрэг үүсгэгдээд шалгагдаад дараагийн асуудал юм байна.

Тэгэхээр Та бүхэн энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ? Шүүхийн шийдвэр эхний анхан шатын шүүхийн шийдвэр гарсан. Ахмадуудын талд гарсан сураг байна. Одоогоор биежиж ирээгүй байна. Цаашдаа гадаа халуун байна. Энэ хэдэн ахмадууд сууж байгаад даралт ихсэх гэдэг юм уу, янз бүрийн асуудал гарвал энэ хариуцлагыг хэн хүлээх вэ?

Хэрвээ ахмадуудын талд шийдвэр гарвал өнгөрсөн хоёр жилийн хугацаанд тэтгэвэрээ авч чадаагүйгээс болоод, эрүүл мэнд нь хохирсон болоод, амь ажил амьдралаараа хохирсон ахмадуудын.../минут дуусав/

П.Анужин: Үйлдвэрчний эвлэлтэй холбоотой асуудал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд Х.Булгантуяа хариулья.

Х.Булгантуяа: Ц.Сандаг-Очир гишүүний асуудалд хариулья.

Үйлдвэрчний эвлэлтэй бид нар. Би одоо яг ажил авсан даруйгаа ерөөсөө дараагийн хоёр жилийн гурван талт нийгмийн түншлэлийн хэлэлцээ хийх яг хугацаа нь болчихсон.

Тэгээд ажил авсан даруйгаа Үйлдвэрчний эвлэлтэй, мөн Ажил олгогчдын эздийн холбоо, Худалдаа, аж үйлдвэрийн танхимтай бид ер нь зөвхөн төрийн албан хаагчдын цалин хангамжийн асуудал ч хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажил олгогчдыг дэмжих гээд ингээд ажилтны Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт гэх мэтчилэн асуудлуудаар бид хурал зөвлөгөөнүүд хийсэн.

Нийгмийн даатгалын манай гурван талт хэлэлцээрийн хангах манай эхний хурал хийгдээд энэ хурал дээр бид төсвийн тодотголыг иймэрхүү байдлаар бид хийж байна. Та бүхэн дэмжиж байна уу, юу гэж бодож байна гээд танилцуулсан. Манай үйлдвэрчний эвлэлийн талууд, ажил олгогч эздийн холбоодын зүгээс ч гэсэндээ дэмжсэн.

Ер нь ингэж дорвитой төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх цаг нь болсон. Ангилал, зэрэглэл маш их ойлгомжтойбайх ёстой. Хоорондоо төрийн албан хаагчдын цалин хэт ялгаатай ялгамжтай байх нь энэ төрд ажиллаж байгаа иргэдийн хувьд ажилчдын хувьд маш их бухимдлыг үүсгэдэг.

Тэгэхээр ийм зарчим руу оруулах нь зүйтэй гэсэн. Цаашид анхаарах тэгэхдээ бид нарт нэлээдгүй асуудлууд байж байгаа. Ялангуяа энэ нэмэгдэл, гүйцэтгэлд тооцдог аргачлал журмууд нь тодорхой биш байна. Заримдаа их үзэмжээрээ өгөөд байдаг. Та нар нэмэгдэлтэй гэж хэлдэг мөртлөө заримдаа төсөв байхгүй гээд өгдөггүй ч гэдэг юм уу ийм асуудлуудыг ярьж байгаа.

Тэгээд манай гурван талт хэлэлцээ удахгүй бид яг албан ёсоор бэлтгэл ажил хангах ажлын хэсэг маань ажиллаад бид 5 сайдтай. Үйлдвэрчний эвлэлээс 5 хүний төлөөлөл, ажил олгогчдоос 5 хүний төлөөлөлтэйгөөр бид хэлэлцээг бид нэлээдгүй өөр шатад хийе гээд ингээд ажиллаж байна. Үүн дээр олон улсын байгууллагуудын ч гэсэн зөвлөгөө аваад явж байна.

Хоёр дахь асуудлын хүрээнд Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн агентлаг байсан. Үүнийг сая Монгол Улсын Ерөнхий сайд хүүхдийн байгууллагуудын 100 гаруй төлөөллүүдтэй уулзсан. Ингэхэд хүүхэд, гэр бүл, залуучууд гээд. Ингээд хүүхэд, гэр бүл хоёр хамтдаа байх нь зөв зүйтэй. Хүүхдийн асуудлыг ярихаар гэр бүлийн асуудал өөрийн эрхгүй яригдаж орж ирдэг юм. Харин залуучууд гэдэг арай өөр сегмент.

Тэгэхээр үүнийг бид илүү их энэ төв маань энэ агентлаг маань хүүхдийн бүр хөгжлийнхөө асуудлыг ч бид төдийлөн сайн ярьж амжихгүй хүүхэд хамгаалал руугаа илүү их чиглэж ажиллаад байгаа юм.

Тэгэхээр залуучуудыг ингээд тусад нь гаргах нь зүйтэй гээд энэ төрийн бус байгууллагуудаас энэ салбарынхнаас санал нь гараад хүүхэд, гэр бүлийн

чиглэл рүү энэ агентлагийг төсвийн тодотголыг дагаж хуульд нь өөрчлөлт оруулж орж ирж байгаа.

Залуучуудын асуудлыг бид хоёр янзаар шийддэг юм билүү гээд Засгийн газраар ороод төсвийн аймаг, орон нутагт чиглэл өгнө өө гэсэн үг.

Нэгдүгээрт, эсвэл залуучуудын асуудлыг аймаг, орон нутгийн Засаг дарга нар өөрсдөө орон нутгийн юуг нь хороог нь ахалдаг. Тийм ээ. Залуучуудын хөгжлийн хороо билүү. Тийм ээ. Тэр хороог нь аймгийн Засаг дарга нар ахалдаг.

Тэгэхээр эсвэл энэ чиглэлийг аймаг, орон нутаг руу бид чиглүүлж болно.

Ахмадын асуудал, эмэгтэйчүүдийн асуудлыг бид тусгайлан агентлаг байхгүй ч гэсэндээ бодлого нь яамнаас гараад дээрээс нь төрийн бус байгууллагуудаар нь ингээд гүйцэтгүүлээд явж байгаатай адилхан залуучуудын асуудлыг ингээд бид төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлээд бодлогыг нь болохоороо аймаг, орон нутгууд руу манай яам мөн оролцоод ингээд гаргаад явах нь зөв зүйтэй байж магадгүй ээ гэж үзэж байгаа.

Мөн нөгөөдөх хоёр дахь нэг боломж нь болохоороо хөдөлмөр, халамжийн хэлтсийн доор байж болох юм гэж үзэж байгаа. Тэгээд Залуучуудын хөгжлийн хуультай болсон. Ямар ч байсан бид эхний шатад тэгэхдээ энэ агентлаг маань нэлээдгүй үүргээ гүйцэтгэсэн. Ямар ч байсан хөлтэй болголоо. 10 гаруй аймгуудад хөгжлийн төвтэй боллоо, бүтэцтэй боллоо, бодлоготой боллоо гээд энэ ахиц дэвшил нэлээдгүй гарсан.

Тэгээд Хүүхэд хамгааллын тухай хууль удахгүй Улсын Их Хуралд өргөн баригдах гэж байгаа. Тэгээд энэ агентлаг маань Хүүхэд, гэр бүлийн агентлаг илүү их болоод.../минут дуусав/

П.Анужин: Нийгмийн даатгалын ерөнхий газраас хүн алга байна. Гэхдээ уг асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Б.Батжаргал дарга хариулах юм уу Б.Батжаргал дарга 4 номерын микрофонд хариулъя.

Б.Батжаргал: Сайн байцгаана уу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Б.Батжаргал. Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Багануур дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэвэр авч байсан 149 иргэний тэтгэврийн асуудал, хуурамч бичиг баримттай холбоотой тогтоолтой асуудал гарсан. Энэ бол хоёр жилийн өмнө эхэлсэн явдал.

Тэгээд энэ хугацаанд нийтдээ одоо байгаа жил нь ямар нэгэн асуудал байхгүй. 25 хүний асуудлыг шийдээд тэтгэврийг нь олгоод явж байгаа. Үлдсэн хүмүүст бид санал тавьж байгаа.

Та нар байгаа жилээрээ тэтгэврээ тогтоолгоод авчих гэсэн ийм саналыг бид адилхан тавиад явж байгаа. Гэхдээ энэ тохиолдолд зарим хүмүүсийн тэтгэвэр нь бүрэн тэтгэвэр байж байснаа хувь тэнцүү тэтгэвэр болох ийм тохиолдол гарч байгаа учраас ихэнх хүмүүс бид эцсээ үзээд ингээд шийдвэрээ гарсаны дараа аваад явмаар байна гэсэн ийм хүсэлтийг тавьж байгаа.

Тэгээд энэ асуудал өчигдөр бид мэдээлэл авсан. Тэгээд өнөөдөр Нийгмийн даатгалын ерөнхий газраас бид баг гаргаад хяналтын багийг өнөөдөр

гаргаж явуулна. Дахиж шалгуулна гэдэг ажлыг бид зохион байгуулна. Баярлалаа.

П.Анужин: Баярлалаа. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуулт асууна.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Би хэд хэдэн асуудлаар байр сууриа илэрхийлэх бодолтой байна.

Төрд олон хулгай байгаа. Түүнээс хоёр хулгайн нэг нь Хөгжлийн банкны хулгай. Хөгжлийн банкны хулгай биднийг өрөнд оруулж байгаа юм. Энэ Хөгжлийн банкны шугамаар авсан гадаад өрийг төлөх. Тийшээ нэг том санхүүжилтийн урсгал.

Хоёрдугаарт нь, нүүрсний хулгай. Манай экспортын 93 хувийг уул уурхай эзэлж байгаа.

Энэ экспортын маань мөнгө хулгайд хэсэг хүний карманд орохгүй улсынхаа төсөвт ороод байсан бол бид хэдийнээ энэ тэтгэвэр, тэтгэмж, цалин мөнгө, халамж нэмэх ийм бүрэн бололцоо байсан.

Тийм учраас би энэ төрийн хулгайтай тэмцэж байгаа Засгийн газар, Ерөнхий сайд, хууль хяналтын байгууллагад чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

Үүний үр дүнд өнөөдөр бид төсвийн тодотгол хийх боломжтой. Тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлс нэмэх тодорхой хэмжээний эх үүсвэртэй болсон гэсэн үг.

Цаашдаа энэ тэмцлээ эрчимтэй болгох юм бол улсын төсвийн орлого үлэмж хэмжээгээр нэмэгдэж, бусад тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх ийм

бүрэн бололцоо үүснэ гэж бодож байгаа юм.

Дээр нь би энд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Б.Алимаа даргад чин сэтгэлийн талархал илэрхийлж байгаа.

Богино хугацаанд тус салбарын сайдаар ажиллаж байхад энэ тэтгэврийн зөрүүг арилгах, хүүхдийн мөнгийг ялгаварлалгүй олгох байр суурийг хатуу илэрхийлж би улмаар тэр хүсэлтийг нь Сангийн яам болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тухайн үед нь тавьж байсан.

2023 оны төсөвт арай чадаагүй. Өнөөдрийн энэ төсвийн тодотголд орж байгаа нь чимээгүй даруухан ажлаа хийж байгаа Б.Алимаа даргын нөмөр нөөлөг, өөрийнх нь мэргэжлийн ур чадвар маш их хэмжээгээр нөлөөлсөн гэдгийг би хэлэх гэсэн гэсэн юм.

Хоёрдугаарт, миний хэлэх гэж байгаа зүйл. Олон гишүүн хэлчихлээ. Би Х.Булгантуяад хэлсэн байгаа. Их Хурал дээр. 161 мянган ахмадын цалин, тэтгэврийн материалын алга болсон. Үүнээс болоод энэ хүмүүс 10 хувиас өөр нэмэгдэл авах боломжгүй болж байгаа юм.

Тэгээд асуухаар энэ 90-ээд оны асуудал гэж байгаа юм. Үүнийг өнөөдрийг хүртэл яагаад яриагүй юм бэ? Энэ хүмүүс тэгээд байнга тэтгэвэр, тэтгэмж нэмэгдэхэд гадна талд нь үлдээд хэлмэгдээд явж байх юм уу? Үүнийг яаж засах юм бэ? Нэг.

Хоёрдугаарт, хүүхдийн мөнгөний асуудал ярьж байна.

Хүсэлтээр нь өгнө л гэнэ, хүүхдийн фондод хандивла л гэнэ.

Өнөөдөр үнийн өсөлт, ахуй амьдралтай холбоотойгоор ийм үгийг сонсохыг ч хүсэхгүй байна шүү дээ.

Гол хүсэж байгаа зүйл нь ямар нэгэн хүнд сурталгүйгээр, хүндрэлгүйгээр хүүхдийн минь мөнгийг өгөөд аль гэж байгаа байхгүй юу.

Их Хурал дээр судална гээд сайд нь хэлчихсэн. Одоо бид юу хийж байна ч гэнэ үү нэг газрын дарга яриад байна. Тийм юм байхгүй. Хүндрэл битгий учруул. Сая С.Ганбаатар гишүүний хэлж байгаа, Ц.Сандаг-Очир гишүүн, Б.Жаргалмаа гишүүний хэлж байгаа үнэн шүү дээ.

Ямар ч хүнд сурталгүйгээр, ямар ч хаалт хязгаарладаггүйгээр хүүхдийн мөнгөө чөлөөтэй авах боломжийг нь ард иргэддээ бүрдүүлж өг. Тэр янз бүрийн тайлбар, мэргэн ухаан гарах гээд боль гэж би шаардаж байна.

Хоёрдугаарт, тэр 161 мянган ахмадын асуудлыг яах юм бэ? Тэгээд ингээд шатаад алга болчихсон юм байна лээ гэдэг яриагаа ингээд хаагаад явах юм уу?

Гуравдугаарт, ярих гэж байгаа зүйл. Мэдээж хэрэг төсвийн тодотгол тодорхой хэмжээ хязгаартай учраас ямар нэгэн шоу хийх, попролт хийх хүсэл алга.

Тэгэхээр зэрэг 2024 оны төсөвт мэдээж хэрэг энэ хулгайтай тэмцэл хийгээд төсвийн орлого маань нэлээн давж биелэх ийм үүд хаалга нээгдсэн гэж ингэж үзэж байгаа юм.

Өнөөдөр энд огт яригдахгүй байгаа асуудал юу вэ гэвэл амьжиргааны баталгаажих түвшнээс доогуурх айл, иргэдийн орлогын асуудал.

Улаанбаатарт 277 мянга, хөдөө орон нутагт 238 мянган төгрөгийн орлоготой байх юм бол амьжиргааны баталгаажих түвшинд байгаа айлууд гэж ингэж үзэж байгаа. Үүнээс доош орлоготой.../минут дуусав/

П.Анужин: Д.Сарангэрэл гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Д.Сарангэрэл: Сарын орлого нь 200 мянгаас дөнгөж давж байгаа 300 мянга хүрэхгүй ийм 26 мянган өрх байгаа талаар Төрийн нарийн бичгийн даргын түр орлон хийж байгаа энэ А.Хишигбаяр гэдэг хүн надад тухайн үед хэлж байсан юм.

Тэгээд би сайдтай энэ асуудлыг ярихаар зэрэг энэ гадаадаар нь хэлье дээ. Тэр bottom family-гийн асуудлыг та хариуцаж та ирээрэй гээд ингээд байгаа.

Тэгэхээр би энэ асуудлыг ингээд ярих гэж байна.

2024 оны төсөвт энэ 26 мянган өрх сардаа 200, 300 мянган төгрөг төгрөг хүрэхгүй байгаа орлоготой айлуудаа яах юм бэ? Энэ талаар 2024 оны төсөвт Та бүхэн оруулж ир. Оруулж ир.

Гуравдугаарт, цалинтай ээж. Бид үнэхээр хийж байгаа дэвшлийг би огт үгүйсгэхгүй.

Цалинтай ээжийг хэд хэдийгээр бид ярихгүй байгаа ч гэсэн ард иргэд хэдийнээ ярьж байна. Нэг памперсны мөнгө хүрэхгүй ийм цалинтай ээж хөтөлбөр гэж юу байдаг юм бэ гэж шүүмжилж байна.

Тухайн үедээ энэ дэвшилтэт хөтөлбөр байсан. Мөнгөний ханш өөр байсан.

П.Анужин: Д.Сарангэрэл гишүүн асуултаа гүйцээгээд асууя.

Д.Сарангэрэл: Айл өрхийн амьдралд тодорхой нөлөөгөө үзүүлээд цалинтай хөтөлбөр өөрийнхөө гүйцэтгэх ролио биелүүлсэн.

Одоогийн түвшинд энэ мөнгөний ханшийн байдал, үнийн өсөлттэйгөөр үнэхээр нэг памперсны ч мөнгө хүрэхгүй, ялангуяа нэмэлт тэжээл хэрэглэдэг бяцхан үрстэй ижийд огт нөлөөлөхгүй байна.

Тийм учраас иргэд энэ “Цалинтай ээж” хөтөлбөрийг үгүйсгээгүй. Одоогийн түвшинд нь таарсан ийм хөтөлбөр хэрэгжүүлээ гэдэг шаардлага тавьж байна. Тэрийг чадахгүй гээд хэлчхэж байгаа юм.

Түүнийхээ оронд одоогийн нөхцөл байдал ийм байна. Цаашдаа бид хулгайтай тэмцээд үр дүнд ингэж ирэхээр зэрэг 2024 оноос цаашдаа энэ асуудлыг анхаарна гэдэг бид тайлбарыг ард иргэддээ өгөх ёстой болохоос чадахгүй, мэдэхгүй гээд сууж байх асуудал байхгүй.

Энэ нэг сайдын асуудал ч биш, энэ Монгол төрийн, Монгол Засгийн газрын асуудал. Иргэдийн асуудалд бид хөлдүү дүлий байх эрхгүй. Ард иргэдээ төлөөлөөд сууж байгаа.

Ер нь засгийн эрх, Улсын Их Хурлын эрх мэдэл гэдэг бол энэ дарга нарын асуудал биш, ард иргэдээ үйлчлэх тухай, тэдний тавьж байгаа шаардлагыг хийж хэрэгжүүлэх тухай асуудал болохоос биш чадахгүй, мэдэхгүй гэдэг тухай асуудал огт биш.

Тийм учраас саяын миний хэлсэн зүйлүүдийг холбогдох яамнууд нэг

бүрчлэн бичээд 2024 оны төсөвт хэрхэн яаж оруулж ирэх төлөвлөгөөгөө одоогоос ярилц гэдгийг би та бүхнээс шаардаж байна. Надад хариулт хэрэггүй.

П.Анужин: Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

С.Чинзориг: Д.Сарангэрэл хариулт авахгүй юм уу?

Би ч асуухгүй дээ. Зүгээр ганц нэг тайлбар л засаг дээр яригдсан юм дээр гишүүдэд тайлбар өгөх.

Хүүхдийн мөнгөний тэр хүсэлтэй холбоотой юмыг Х.Булгантуяа нарын сайд хариулсан л болов уу даа.

Би бодохдоо хүсэлт өгсөн хүүхдэд нь энэ нэмэлт 9 хувийг нь олгох нь зүйтэй л гэж засаг дээр тэгж л ярьсан шүү дээ. Тухайлбал, энэ чинь хөрөнгө орлоготой, тэр бизнесүүд нь, тэр Их Хурлын гишүүд нь авахгүй байх, татгалзах тэр эрхийг нь нээж өгөх хэрэгтэй шүү дээ.

Тухайлбал, тэр Буянгийн Жагаа авахгүй гэвэл заавал тэрийг хүчээр өгөхгүй. Их Хурлын гишүүд, улс төрийн албан тушаалтнууд, Засгийн газрын гишүүд ч гэсэн тэр хүүхдэдээ авахгүй гэвэл тэгээд тэр эрхийг нь нээж өгч байгаа л асуудал шүү дээ. Тэр утгаас нь гишүүд ойлгоосой гэж хүсэж байгаа юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан зөв ойлголт өгөх хэрэгтэй. 161 мянган иргэдийн архивт материал нь байхгүй учраас тэтгэвэр нэмэгдэхгүй гэсэн юм ярьчихсан юм уу. Гишүүд тэгж яриад байх юм. Би тэгж ойлгохгүй байна.

Яах вэ, амьдрал баян. Янз янзын материал байдаг. Дутуу ч байдаг. Зарим нь 1990 оны хувьчлалаар материал нь

алга болчихсон. Нэгдэл хувьчлалаар тээврийн компаниуд, байгууллагууд хувьчлагдсан, барилгын компаниуд хувьчлагдсан, бүрэн материал нь архивд байхгүй энэ тэр гээд зөндөө юм байдаг л даа. Амьдрал дээр.

Тэрийг чинь ажилласан жилийг нь шүүх тогтоогоод, бас тухайн үед нь хамт ажиллаж байсан хоёр, гурван хүний тодорхойлолтыг нь аваад шүүх ажилласан жилийг нь ингээд тогтоодог юм бий.

Яагаад тэр материал нь архивт байхгүй учраас тэтгэвэр нэмэгдэхгүй гэсэн тийм ойлголт явчихсан юм. Хэрвээ тийм ойлголттой байгаа бол залруулах хэрэгтэй.

Хүн болгоны тэтгэврийн зөрүү арилах гэхээр хүн болгоны тэтгэвэр нэмэгдэхгүй нь тодорхой.

Тэрийгээ зөв ойлголт, тайлбарыг нь өгөх хэрэгтэй л дээ. Архивт материал нь байхгүй учраас эдгээр улсууд итгэлцүүр хэрэглэснээр тэтгэвэр нэмэгдэхгүй гэж. Тэгж хариулж болохгүй л гэж бодож байгаа юм.

Яагаад итгэлцүүр хэрэглэхээр тэтгэвэр нэмэгдэхгүй үлдэж байгаа хэсэг байх вэ гэхээр бид чинь олон жил ингээд нөгөө тэтгэвэр бага байна, доод тэтгэврийн хэмжээ бага байна, нийт тэтгэвэр авагчдын дийлэнх масс нь бага тэтгэвэртэй байна гэж байгаад авч байсан цалингаасаа, шимтгэл төлж байсан цалингаас нь үл хамаараад доод тэтгэврийг асар их өндөр нэмэгдүүлж ирсэн шүү дээ.

Өнгөрсөн жил гэхэд бид бараг хоёр дахин дэмжсэн. Одоо тэгээд доод тэтгэвэр авч байгаа иргэдийг чинь одоогийн тэр 2060 гээд итгэлцүүрээр

цалинг нь шинэчлэн тогтооход яг одоогийн тэр 2060 гэсэн итгэлцүүрээр цалинг нь шинэчлэн тогтоосон тэр цалингаас нь бодоод олгох хэмжээний тэр доод тэтгэвэр чинь тэр түвшинд л хүрчихсэн байгаа байхгүй юу.

Тийм учраас итгэлцүүр хэрэглэсэн ч гэсэн тэр цалин нь шинэчлэн тогтоогдохгүй байгаа улсуудын тэтгэвэр нь нэмэгдэхгүй. Итгэлцүүр хэрэглэсэн ч гэсэн тэтгэвэр нэмэгдэхгүй үлдэж байгаа гэдэг ийм чиглэлээр нь тайлбар өгөх л хэрэгтэй л дээ. Хөдөлмөрийн яамныхан.

Тэгэхгүй бол тэр материал нь байхгүйгээс эдгээр иргэдийн тэтгэвэр нэмэгдэхгүй гэсэн ойлголт. Би бол тийм ойлголт яваагүй болов уу. Хэрвээ тэгж явж байгаа нь бас буруу ойлголт болчихно шүү дээ. Тэгж яривал бид тэгээд цаашдаа ер нь одоо тэгээд материал байхгүй бол яаж тэтгэвэр тогтоосон юм. Яагаад тэгээд тэтгэврийг нь олгоод байсан юм гэдэг юм руу л явна шүү дээ.

Тэгэхээр нэг зөв ойлголт өгөх нь зүйтэй болов уу гэж. Би тэгээд ийм л зүйлийг л тодруулга л хэлье. Гишүүдэд. Зөв ойлголт өгөх үүднээс л.

П.Анужин: С.Чинзориг гишүүнд баярлалаа.

Буланы Бейсийн гишүүн асуулт асууна.

Б.Бейсен: Би энэ сая орон нутгаар яваад ирлээ л дээ.

Баян-Өлгий аймгийн Хотгор баг, Хотгорын нүүрсний уурхайн эмнэлгийг татан буулгана гээд байгаа. Тэнд цэцэрлэг, эмнэлэг байгаа.

Магадлан итгэмжлэлд ороогүй учраас тэр санхүүжилт нь түр зогсоод эмнэлгийг татан буулгах шийдвэр гарсан. Гэтэл тэнд сургууль, цэцэрлэг, захиргаа өдөртөө Увс, Ховд, баруун гурван аймгаас 100-аас 105 машин очдог.

Сая энэ төсвийн тодотгол дээр тэр нэг гүйцэтгэлийг нь тавьсан гээд ярьж байна. Одоо эмнэлгийн ажилчид тэдний төсөв тавигдсан уу?

Хоёрдугаарт, тэр Ховд баг, Улаан чулуу баг дээр эмнэлэг нь баригдсан. Тэнд мөн адилхан цэцэрлэг, сургууль байж байгаа.

Тэгээд тэр ажилчдынх нь төсвөөс тодотголд орж ирээгүй. Тэгээд 2024 онд орж ирэх үү? Энэ талаар асууя. Энэ яагаад тавигдахгүй байна?

Дараа нь энэ Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтийн тухай асуумаар байх юм. Одоо ер нь эмч, эмнэлгийн ажилчдыг цалин тийм өндөр авч байна гэж байна. Бодит байдлаар тийм юм байхгүй, ерөөсөө. Цалингийн үндсэн сүлжээг нь хоёр дахин нэмж байж дараа нь гүйцэтгэлийн санхүүжилтээр өгвөл болж байгаа юм.

Тэгэхээр чинь эмнэлэг ч аппарат, тоног төхөөрөмж авчих боломжтой.

Одоогоор чинь бүх юм чинь тэр гүйцэтгэлийн санхүүжилт чинь ажилчдын цалин, бусад юманд явчхаад байна шүү дээ.

Зуны цагт энэ сүрьеэ, халдварт, арьс өнгөний тасаг гээд хүн хэвтдэггүй тасгууд байж байгаа. Үүнийг мөн адилхан энэ даатгалын юунд оруулчихсан. Уг нь энэ халдварт өвчин, бэлгийн замаар дамжих халдвар, ДОХ ч

юм уу, бусад юмыг чинь төрөөс хариуцдаг байсан. Даатгалд оруулсан.

Энд ажиллаж байгаа ажилчид хүн хэвтүүлэхгүй бол яах юм? Тэгээд одоо. Худлаа түүвэрлэлт өгөх үү? Яг клиник дээр ажиллаж байсны хувьд та нар зуны цагт очоод үзээрэй. Бараг хүн хэвтдэггүй шүү дээ. Тэгээд цалинг тэр гүйцэтгэлийн санхүүжилтээр яаж олгох юм?

Ялангуяа халдварт өвчний талаар ярья гэж бодож байна л даа.

2022 оны жилийн эцсийн байдлаар өвчний нас баралт 225 тохиолдмоор коронавируст халдварын. Энэ 142 нь коронавируст халдвар. 66 нь сүрьеэ. Төрөлхийн тэмбүү 6 байгаа. Тэгээд ДОХ нэг хүн нас барсан байгаа.

2022 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд бэлгийн замаар дамжих халдвар 10 мянга 718 тохиолдол бүртгүүлснээс 1378 тохиолдлоор нэмэгдсэн байгаа.

Үүний судалгааг нь хийхгүй бол одоо ДОХ чинь сум, багийн түвшинд хүрчихсэн байна шүү дээ. Энэ дээр төсөв тавигдах уу? Сайд аа. Үүнийг яаж шийдэх вэ?

Ер нь урьд нь зөндөө төсөл, хөтөлбөр байсан. 2020-2021 онд тэрийг бүгдийг нь хассан байгаа. Харин Глобал сангийн юугаар нэг юу явдаг. Энэ ч бас тодорхой биш байна л даа.

Энэ талаар тодорхой асууя. Дараа нь тодруулья.

П.Анужин: Б.Бейсен гишүүний асуултад Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг хариулна.

С.Чинзориг: Манайхан Баян-Өлгий, Ховд аймгийн багийн эмнэлэгтэй холбоотой асуудал дээр хариулт өгчхөөрэй.

Гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой асуудал дээр одоо бид ингээд төсвийн тодотгол хийчихээр Б.Бейсен гишүүн ээ, тарифын өөрчлөлтүүд хийгдэнэ. Өмнө нь ч би бас Байнгын хороонд ярьж байсан. Тарифын өөрчлөлт хийе. Ялангуяа алслагдсан сумдын эрүүл мэндийн байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн явуулах чиглэлээр тарифын өөрчлөлт хийх хэрэгтэй байна. Газар зүйн коэффициент гэж юм гаргая гээд байгаа юм.

Хоёрдугаарт, одоо ингээд цалингийн өсөлт хийгээд, цалингийн сангийн өсөлтийг нэмэгдүүлээд цалингийн доод жишгийг нэмэгдүүлж байгаа учраас бид энэ цалингийн өсөлтийг шингээсэн тарифын өөрчлөлт хийж 7 сарын 01-нээс хэрэгжүүлж эхэлнэ.

Энэ хүрээндээ тодорхой хэмжээгээр цалингийн нэмэгдлүүд авагдана.

Би түрүүн хэлсэн. Ер нь манай салбар дээр энэ цалин хөлснийхөө бүтцийг жаахан өөрчлөлт оруулмаар юм байна лээ. Үндсэн цалингаа нэмэхгүй, тэр олдож байгаа санхүүжилтээсээ цалин хөлс нэмэгдүүлэхдээ дандаа урамшууллыг нь нэмэгдүүлээд яваад байгаа асуудал байгаа. Үүнийг цэгцэлнэ ээ. Цэгцэлнэ гэсэн ийм бодолтой байна.

Хоёр дахь асуудал. Би тантай санал нэг байгаа юм.

Энэ халдварт өвчинтэй холбоотой асуудал. Ялангуяа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, тандалт, судалгаатай холбоотой асуудал гүйцэтгэлийн

санхүүжилтээр санхүүжилт авна гэдэг боломжгүй юм байна лээ. Тухайлбал, ХӨСҮТ хоёр аргаар санхүүжихээс өөр үггүй юм байна лээ.

Яг тэр хэвтэн эмчлүүлэх нь гүйцэтгэлийн санхүүжилтийн аргаар явдаг. Тэр бидний яриад байгаа нөгөө урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, тандалт судалгаа нь улсын төсвөөсөө шууд санхүүжилт аваад явдаг аргаар явахгүй бол болохгүй юм байна лээ.

Би ирэх долоо хоногт нөгөө бидний яриад байгаа Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулиа засагт оруулаад Их Хуралд өргөн барина.

Тэрүүгээр бидний ярьж байгаа ерөөсөө нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ улсын төсвөөс шууд санхүүжилтээ авдаг байхаар. Тэр хэвтэн эмчлүүлж байгаа асуудал нь гүйцэтгэлийн санхүүжилтээрээ санхүүжилтээ авдаг байх гэсэн ийм чиглэлээр ялгаж салгахгүй бол бүгдийг ингээд гүйцэтгэлийн санхүүжилтээр аваад явна гэдэг бол бас болохгүй байгаа.

Ялангуяа нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, энэ халдварт өвчний илрүүлэгтэй холбоотой, тандалт судалгаатай холбоотой асуудлууд нь болохгүй байгаа юмнууд байгаа.

Тийм учраас энэ тогтолцоо болоод энэ санхүүжилтийнхээ аргад жоохон өөрчлөлтүүд оруулах ийм чиглэлийн өөрчлөлтүүд хийнэ гэдгийг хэлье.

Ингээд 7 сарын 01 гэхэд энэ бүх өөрчлөлтүүд, тэр үндэсний зөвлөлийн 01 тогтоол, 05 дугаар тогтоол, тэгээд бидний нөгөө яриад байдаг анхан шатын эрүүл мэндийн байгууллагуудын 14 удаа

шалгуурыг нь 10 шалгуур болгож өөрчлөх, их олонлогийн хяналттай холбоотой асуудлыг боловсронгуй болгох гээд энэ бүх асуудлыг нэг талд нь шийднэ. Шийдэхээр ажиллаж байгаа.

Ингээд 7 сарын 01-нээс мөрдүүлж эхэлнэ.

Тэр багийн 2 эмнэлэгтэй холбоотой юм дээр манайхан тодорхой хэлэх хариулттай байна. Яг тэр Баян-Өлгий, Ховд аймгийн 2 багийн эмнэлгийн санхүүжилтийн юм ярих шиг болсон доо. Л.Мөнхцэцэг, Л.Бямбасүрэн хэлэх юм байна уу.

П.Анужин: Гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Дэгээрээ гишүүд төсвийн тодотголтой холбогдуулан гишүүдээс санал ирээгүй.

Төсвийн тодотголын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хурлынхаа хэлэлцэх асуудлын дараагийн асуудалд орёё.

Хоёр.Монгол Улсын олон талт олон улсын гэрээ, гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан сонсох

Түрүүн ажлын хэсгийг танилцуулсан байгаа. Ажлын хэсгийн гишүүдийг танхимд урьж байна.

Ажлын хэсгийн ахлагч Цэндийн Мөнх-Оргил гишүүнийг танилцуулгаа хийхийг урьж байна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор ажлын хэсэг байгуулагдсан.

Ажлын хэсгийн гол зорилго Монгол Улсын олон талт олон улсын гэрээний үүргийн хэрэгжилт, тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний хороонд хүргүүлж байгаа байдал. Мөн тайлангийн мөрөөр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга

хэмжээнүүдэд үнэлэлт, дүгнэлт өгөх ажил байсан юм.

Дэд ажлын хэсэг байгуулж ажилласан. Дэд ажлын хэсэгт манай яам, Тамгын газар, агентлагийн газар гээд 14, 15 байгууллагынхан орсон.

30 гэрээний үүргийн хэрэгжилтийг бид ярьж байгаа.

Ажлын хэсэг, дэд ажлын хэсэг нийт 10 гаруй удаа хуралдсан.

Хууль зүйн байнгын хороо 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа Хууль зүй, дотоод хэргийн яамны тайлан өгч байгаа гэрээнүүдийн хэрэгжилтийг хэлэлцсэн.

Нийт 30 гэрээ байгаа.

Гишүүд ээ, яагаад энэ олон улсын гэрээний хэрэгжилтийн тайланг ингэж бид Байнгын хороод болгоноороо хэлэлцэх гарцаагүй шаардлага гарчхаад байгаа юм бэ гэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйл дээр тодорхой заачихсан юм.

Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гээд.

Ерөөсөө шууд Монгол Улсын хууль болчхож байгаа байхгүй юу. Шууд Монгол Улсын хууль болчхож байгаа юм. Манайх өөрөөр хэлбэл энэ “**монизм систем**”-ийг хүлээгээд авчихсан. Нэгдмэл систем гээд.

Тэгэхээр үүний гол гарч байгаа үр дагавар нь яах вэ гэхээр Монгол Улсын шүүгч, прокурор, хууль хяналтын байгууллагууд энэ олон улсын гэрээний заалтаар шууд хүнд эрх олгодог, үүрэг хүлээлгэдэг, Засгийн газарт эрх олгодог, Засгийн газарт үүрэг хүлээлгэдэг эрхтэй болчхоод байгаа байхгүй юу.

Бид хууль баталж байгаатай л адилхан байгаа байхгүй юу. Тийм ээ.

Тэгэхээр энэ нь ерөөсөө манайд байхгүй болчхоод байдаг. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Их Хурлаас л баталсан хууль нь хууль.

Гэрээ, конвенцууд ер нь яах вэ дээ тэгээд л гэрээ конвенц байж л байдаг юм.

Ер нь нэг их хэрэгжих албагүй юм байна гэсэн нэг ийм буруу ойлголт бий болчхоод. Үүнийг хэдүүлээ засаж залруулах их чухал шаардлага гарчхаад байгаа юм.

Нийт 294 олон талт олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэж орсон байгаа юм. Үүний задаргаа нь хүний эрхийн 48, хүрээлэн буй орчны 24, гэмт хэрэгтэй тэмцэх 30 гээд.

Нэгдсэн Үндэстний Байгууллага болон олон улсын байгууллагуудад энэ конвенцын заалтыг бид ингэж хэрэгжүүлж байна шүү гэдэг тайлан хүргүүлдэг 30 конвенц байгаа юм. 30 конвенц.

Өөрөөр хэлбэл 242 конвенцоос 30-д нь бид олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ ингэж хэрэгжүүлж байна шүү гэдэг тайлан өгдөг. Үүний 18 нь хүний эрхийн, байгаль орчин 5, гэмт хэрэгтэй тэмцэх 4, эрүүл мэндийн 3 гээд нийт манай Байнгын хороонд хамааралтай үндсэндээ 21 конвенц болчхоод байгаа юм.

Тэгээд 30 конвенцыг задлаад үзэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Зам, тээврийн яам, Эрүүл мэндийн яам үндсэндээ гол зонхилох үүрэгтэй оролцох ёстой болчхоод байгаа юм.

Ингээд энэ 30 конвенцыг бид нэг бүрчлээд 3 жилийн хугацаанд задалж байна л даа. Зөвлөмж болгоноор нь үзээд, хуулийн заалт болгоноор нь үзээд, Засгийн газрын хуулийг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай нь уялдуулаад үзэхээр ерөөсөө нийтлэг 7, 8 том дутагдал байна.

Нэгдүгээрт, ерөөсөө манай төрийн байгууллагуудын уялдаа холбоо, зохицуулалт, харилцан мэдээлэл байхгүй байна гэдэг дүгнэлт гарч байгаа юм. Жишээ нь, Эрүүл мэндийн яам нь яг ямар ажил явуулж байгааг бусад байгууллагууд нь мэддэггүй. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд

харьяалагдсан конвенцын хэрэгжилт нь хаана байгааг нь нөгөө байгууллагууд нь мэддэггүй нэг ийм проблем байгаа юм.

Нөгөөдөх нь, түрүүн миний ярьсан шүүх, олон улсын гэрээний заалтыг хэрэгжүүлэх практик, дадлага туршлага байхгүй. Шүүхийн байгууллагын албан хаагчийн олон улсын гэрээний талаарх мэдлэг дутмаг байна гэж байгаа юм.

Тэгэхээр энэ 30 конвенцыг бүгдээрээ Улсын Их Хурал дээр ярьж, хэлэлцэж дуусчхаад Улсын Их Хурлаас тогтоол батлаад Засгийн газарт үүрэг даалгавар өгье гэж бодож байгаа юм.

Жишээ нь, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Их Хурал хамтраад нийт шүүгч нарт, шүүхийн ажилтан, прокурорын байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт явуулаад хүний эрхийн 18 конвенц ийм заалттай юм шүү. Ингэж хамгаалах ёстой юм шүү.

Үүний цаана ийм үр дагавартай юм шүү. Энэ заалтыг хэрэгжүүлэхгүй бол ийм арга хэмжээ авдаг юм шүү гэж ийм сургалтуудыг нь шүүгч нарт зориулж хийх. Нөгөө талаас олон нийтэд мэдээлэл хүргэж байх ёстой юм билээ.

Гурав дахь нийтлэг дутагдал бол энэ төрийн байгууллагын хүний нөөц тогтворгүй гэдэг асуудал байгаа юм.

Энэ одоо жишээ нь, яаж байна вэ гэхээр нэг хүн нэг конвенцын хэрэгжилтийг хариуцаж яваад, тайлан хийгээд сууж байтал ажлаа солиод цоо шинэ хүн орж ирээд дараагийн ажил, конвенцоо хэрэгжүүлэх гээд явчихдаг.

Тэгээд өмнө нь ямар зөвлөмж гаргасан юм. Тэр зөвлөмж хэрэгжсэн юм уу, хэрэгжээгүй юм уу дараагийн хүнд

ерөөсөө мэдээлэл очдоггүй. Одоо манай нийт төрийн аж ажлын нэг ийм том нийтлэг дутагдал байна шүү дээ. Тийм ээ.

Ажлаа өгөөд л явчихсан бол эргэлт, холбоо байдаггүй. Нөгөө хүн нь шинэ ажил авчихсан бол өмнөх хүнээсээ юмаа нэхдэггүй. Ингээд хүний нөөцийн тогтворгүй байдал ямар байдалд хүргээд байна вэ гэхээр бид нарт энэ институцийн болон байгууллагын ой санамж ерөөсөө бүрдэхгүй байна. Үүнийг бүрдүүлэх асуудал их чухал байна.

Тэгэхээр бид ярьж байгаад Их Хурал, Засгийн газарт ямар үүрэг даалгавар өгөх ёстой болчихоод байна вэ гэхээр энэ гэрээ, конвенцуудын хэрэгжилт дээр нэг дата бааз үүсэх ёстой юм байна. Дата бааз.

Энэ конвенц дээр ийм үүрэг өгсөн шүү. Ийм амлалт бид хүлээсэн шүү. Үүнийгээ ингэж хэрэгжүүлсэн шүү. Энэ нь дутуу байсан. Үүнийг нь ингэж хэрэгжүүлсэн. Одоо ийм юм хийх ёстой гэдгийг бүгдийг нь нэгтгэж гаргаж өгч байдаг. Тэнд нь төрийн бус байгууллагууд, иргэд, олон нийт, төрийн бус байгууллагынхан, яам, Тамгын газрынхан ороод мэдээллээ солилцож байдаг нэг юм хэрэгтэй байна.

Дараагийн нэг том дутагдал бол энэ олон улсын гэрээнд нэгдэн орохдоо үүсэж болох хууль, эрх зүй, нийгэм, эдийн засаг, санхүүгийн үр нөлөө, хүлээх үүрэг хариуцлага, тэдгээрийг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг нарийвчлан үнэлэхгүй байна гэдэг дүгнэлт гарч байгаа юм.

Одоо нэг төрийн бус байгууллага энэ конвенцод нэгдмээр байна гээд л лобби хийгээд л яваад байдаг. Эсвэл нэг олон улсын байгууллага лобби хийчихдэг. Тэгээд л ерөөсөө энэ конвенц

нэгдэх нь чухал юм байна гээд л нөгөө сүр пар хийгээд орчихдог практик их байна.

Гэтэл яаж энэ конвенцуудад нэгдэж орж байх ёстой вэ гэдэг журам, дэг нь болохоор нөгөө хууль тогтоомжийн хууль дээрээ уг нь заагаад өгчихсөн. Тэр хэрэгждэггүй зовлон үүсчхээд байна.

Тэгэхээр энэ дээр Их Хурлын гишүүд бидний Байнгын хороодын дутуу ажиллагаа байгаа юм.

Засгийн газраас оруулаад ирэхэд нь бид тэр хууль тогтоомжийн хуулийнхаа шаардлагыг бариад дутуу байна. Хууль тогтоомжийн хуулиараа та нар олон улсын конвенцод нэгдэж орохдоо зөвхөн санхүүгийн, зөвхөн хууль эрх зүйн ямар өөрчлөлт гарахаас гадна эдийн засгийн, нийгмийн ийм ийм сөрөг тал гарах нь, ийм ийм давуу тал гарах нь, үүнийг хэрэгжүүлэх хүн хүч алга, үүнийг хэрэгжүүлэх ийм бололцоо алга, ийм судалгаануудаа хийж ир ээ.

Одоо бид яаж байна вэ гэхээр конвенцод нэгдэж орчихоод орчихсоныхоо дараа дотоодын хууль тогтоомжоо янзлаад байгаа байхгүй юу. Бусад орнууд.

Одоо жишээ нь, өндөр хөгжилтэй орнууд, Япон яаж байна вэ гэхээр конвенцод нэгдэж орох хуулийг соёрхон батлах, конвенцыг соёрхон батлах хуулийн төсөл өргөн барихдаа тэр конвенцыг дагаж гарах бусад хуулиудын өөрчлөлтийг нь хамт өргөн барьчихаж байгаа юм. Бүгдийг нь.

Одоо жишээ нь, юу гэдэг юм, Далайн эрх зүйн конвенцод нэгдэж орлоо гэхэд Япон Улсын нийт 145 хуульд 457 өөрчлөлт орох нь ээ. Засгийн газрын баталсан 215 журамд 751 өөрчлөлт орох

нь ээ гээд бүгдийг нь ингээд ийм том том хавтас болгоод хамт өргөн барих ёстой байгаа байхгүй юу.

Тэрийг нь Их Хурал үзээд энэ чинь болж байна. Тэгэхдээ энэ журмыг хэрэгжүүлэх бололцоо алга.

Тийм учраас конвенцод одоохондоо нэгдэж орохгүй ээ. Хүлээж бай. Бололцоогоо бүрдүүл. Хүн хүчний бололцоотой бол, санхүүгийн нөөц бололцоотой бол. Тэгж байж ор гэдэг.

Өөрөөр хэлбэл бид олон улсын конвенцод нэгдэж орно гэдэг шууд хүчин төгөлдөр болоод үйлчлээд явчих учраас тэрийг шууд хэрэгжүүлэх ёстой болчихоод байгаа байхгүй юу.

Шууд хэрэгжүүлж чадахгүй бол нэгдэж орох хэрэггүй болчихоод байгаа юм. Шаардлагагүй. Хэрэгжүүлж чаддаг болсон хойноо орох нь чухал байгаа байхгүй юу.

Тэгээд үүнийг хэдүүлээ хэвшүүлмээр юм байна лээ.

Гэрээний хэрэгжилтийн тайлан, хэлэлцүүлсэн дүн, өгсөн зөвлөмжийг Улсын Их Хурал, Засгийн газарт танилцуулах, биелэлтэд хяналт тавих нэгдсэн механизм байхгүй.

Энэ ерөөсөө ийм юм болчихоод байгаа юм. Жишээ нь, манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны экспертүүд, мэргэжилтнүүд, үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын холбоо эд нар олон улсын хөдөлмөрийн байгууллага дээр очоод жишээ нь, энэ 8 сард Албадан хөдөлмөрлөх эрхийг хориглох конвенцын тайлан тавих гэж байгаа байхгүй юу. Эд нар маань очоод тайлангаа тавьчихдаг.

Тэгээд сайн, муу, дунд ч гэдэг юм уу янз янзын дүн аваад ирнэ. Зөвлөмж гарна. Тэгээд тэр зөвлөмж нь ерөөсөө тэр чигтээ тэндээ хадгалагдчихаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр одоо энэ тийм ээ, юу ч болсон юм бүү мэд. Их Хурал ч мэддэггүй, сайд, дарга нар нь ч мэддэггүй.

Тэгэхээр бид ямар практик нэвтрүүлэе гэж зөвлөмж гаргах гэж байгаа вэ гэхээр тайлангаа тавиад ирэх болгон дээрээ Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд яг адилхан ирж тайлангаа тавьж бай гэдэг зөвлөмж гаргамаар юм билээ. Тийм ээ.

Жишээ нь, албадан хөдөлмөрлүүлэхийг хориглох олон улсын конвенцийн хэрэгжилтийг манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан, холбогдох байгууллагынхан очоод 8 сард тайлангаа тавьчихлаа шүү дээ.

Ирээд 10 сард Улсын Их Хурал, манай Байнгын хороон дээр ирээд бид тайлангаа тавилаа. Конвенц ийм ийм заалттай. Манайд хууль тогтоомж ийм, хэрэг хэрэгжилт нь ийм, сайн тал нь ийм, дутуу тал нь энэ.

Үүнийгээ ингээд тавьсан чинь нөгөө олон улсын экспертүүд чинь бид нарт энэ чинь дутуу байна, үүнийгээ ингэж зас гэж байна, үүнийгээ ойлгохгүй байна, тодруул гэж байна гээд ингээд бид нарт 15 зөвлөмж өглөө. Энэ 15 зөвлөмжийг бид ингэж хэрэгжүүлэе гэж бодож байна.

Улсын Их Хурал ийм юм хиймээр юм байна шүү. Та нар юу гэдэг юм Хөдөлмөрийн хуулийнхаа энэ заалтыг ингэж янзалмаар юм байна гэж бид

үнэлж байна. Цаад экспертүүд чинь тэгж үнэлж байна. Засгийн газар журмаа ингэж янзалмаар юм байна. Бид ажлаа ингэж зохицуулмаар юм байна. Засаг дарга нарыг ингэж сургамаар юм байна гэдэг ийм юмнууд орж ирж баймаар юм байна лээ.

Тэгж байж Их Хурал мэдээлэлтэй болдог. Хамгийн гол нь Их Хурлаар дамжиж олон нийт мэдээлэлтэй болох ёстой байгаа юм. Өөрөөр хэлбэл эд нар сонин дээр ч юм уу, өөрийнхөө веб сайт дээр тэр тайлан тавиад олон нийтэд хүрэхгүй байгаа байхгүй юу.

Олон нийтэд хүрэх арга нь болохоор Их Хурал дээр тэр тайлангуудыг хэлэлцэж байх хувилбар юм байна лээ.

Дараагийн маш том нийтлэг дутагдал бол энэ тайлан бэлтгэх, хэрэгжилтийг хангах, тайланг очиж хамгаалах ажилд нийтлэгдээ энэ төрийн бус байгууллагуудын оролцоо маш сул байгаа юм.

Энэ дээр ганцхан арай жоохон дэвшилтэй нь энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах конвенцын хэрэгжилт дээр манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөгөө шүхэр байгууллагыг татаж оролцуулж төлөөллийг нь байлцуулж тайлангаа тавьдаг юм байна гэж ойлгож байгаа.

Бусад юмнууд дээр дутагдалтай байна гэсэн дүгнэлт гараад байгаа юм.

Уг нь бид яах ёстой вэ гэхээр энэ чинь Засгийн газар тайлан хэрэгжүүлж тайлангаа тавихаасаа гадна Засгийн газар олон нийтэд тайлан тавьж байх ёстой

байхгүй юу. Нийт Монголын иргэдэд. Тийм ээ.

Жишээ нь, юу гэдэг юм Хүүхдийн эрхийг хамгаалах конвенцын хэрэгжилтийг бид Засгийн газар ингэж хэрэгжүүлж байна. Заалт заалтаар нь. Энэ болж байна, энэ болохгүй байгаа, энэ дээр бид ийм дүгнэлт хийж байна гээд Улсын Их Хурал дээрээ тайлагнаж байдаг.

Үүнийхээ хажуугаар хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудад тайлангаа тавьж байх ёстой байхгүй юу. Тийм ээ.

Төрийн бус байгууллагууд нь Засгийн газартайгаа хамтраад нийлээд нэгдсэн нэг тайлан боловсруулаад олон улсын байгууллагад хүргэж байх ёстой.

Түүнээс биш зөвхөн Засгийн газар нь тэнд хөлсөө арчаад л ингээд л суугаад байх биш. Энэ чинь нэг Засгийн газрын тайлан гэхээсээ гадна энэ чинь нийтдээ Монгол Улс тайлангаа тавьж байна шүү дээ.

Тэгэхээр энэ төрийн бус байгууллагуудын оролцоог хангах ажил чухал байгаа юм.

Дараагийн нэг. Бид нар Их Хуралд ч гэсэн анхаарах ёстой юм бол ерөөсөө энэ олон улсын гэрээ конвенцуудын орчуулгын асуудал их зовлонтой байна.

Янз янзаар орчуулчихдаг. Зөвлөмжүүдийг нь ч гэсэн янз янзаар орчуулчихдаг. Тэгээд зөвлөмжүүдийг нь одоо жишээ нь, энэ ажлын хэсгийг ахлаад бид ажиллаж байхад тал талдаа ерөөсөө тийм л ойлголтод хүрч байгаа байхгүй юу. Монголоор уншаад ерөөсөө ойлгодоггүй. Яг юу гээд зөвлөчихсөн юм бэ наадах чинь ойлгогдохгүй байна шүү

дээ. Алив английг нь аваад ир гэхээр англи дээр нь маш ойлгомжтой тодорхой биччихсэн.

Жишээ нь, ингэж байгаа байхгүй юу. Энэ олон улсын энэ Хүүхдийн эрхийн конвенцын экспертүүд бидэнд юу гэж зөвлөөд байгаа вэ гэхээр бооцоот морин уралдаанд насанд хүрээгүй хүүхдүүдийг уралдуулаад байна энэ чинь хүүхдийн хөдөлмөрийг мөлжиж байгаа хэлбэр юм гэж. Одоо нyoанстай тайлбарлаад байна шүү дээ.

Үүнийг нь орчуулаад тайлбарлахлаараа морин уралдаанд хүүхэд битгий оролцуул гэсэн гэсэн маягтай ингээд тайлбарлаад явчихдаг.

Тэгэхээр Монгол хүн юу гэж ойлгох вэ гэхээр үгүй ээ энэ чинь Монгол хүн хүүхэд морио л унана шүү дээ гээд. Энэ олон улсын байгууллагынхан чинь яах гээд байгаа юм. Монгол хүнийг битгий морь уна гэж хэлээд байгаа юм уу гээд. Үгүй.

Нөгөөдүүл нь бүр тэр зөвлөмждөө тэгж хэлээд байгаа байхгүй юу. Монгол хүн өөрийнхөө түүх, соёл, ахуй уламжлалаа авч явахад мэдээж морио унана. Хүүхэд уралдаанд уралдана. Тэр бол хэн ч хориглож чадахгүй. Хориглох ч эрх байхгүй. Тэр ингээд явдгаараа явна.

Юу гэж хэлээд байгаа вэ гэхээр хүн бооцоотой, өндөр ашигтай уралдаанд морио уяад тэндээс ашиг олоод тэр ашиг олохын төлөө өөртөө хамаагүй хүний нялх хүүхдийг ашиглаад байна шүү дээ л гэж байгаа байхгүй юу. Тийм ээ.

Үнэхээр та тэр морин уралдаанд хүүхдээ уралдуулах гээд байгаа бол өөрийнхөө хүүхдийг уралдуул. Хэрвээ бүр тэндээ тулаад байгаа бол. Үгүй бол насанд хүрсэн хүүхэд уралдуул.

Түүнээс биш аав ээж нь хүүхдээ морь унуулаад, ах дүү нар хоорондоо морь уралдуулаад Тийм ээ. Үүнийг хориглоогүй ээ. Хүүхдээр битгий мөнгө олоод бай гээд зөвлөөд байгаа байхгүй юу.

Гэтэл үүнийг нөгөө орчуулга, зөвлөмж дээрээ бүрэн гаргаж өгөхгүй болохоор бид нэг буруу ойлголттой болчихоод яваад байдаг. Тэгээд л энэ олон улсын байгууллагынхан монгол хүнийг морь унуулахгүй гээд байна гээд. Нөгөөдөх нь болохоор хүүхэд мөлжөөд байна шүү дээ. Эрхийг нь хамгаалаач ээ л гэдэг асуудал яригдаад байгаа байхгүй юу. Гэх мэтээр.

Тэгээд энэ үг үсэг, тайлбар эд нар их дутуу орж ирээд байгаа юм.

Нийтлэг дутагдлууд ийм байгаа юм. Тэгээд би маш товчхон хоёр, гуравхан конвенцын дэлгэрэнгүй ярьчихъя.

Хамгийн чухал конвенцууд нь. Энэ эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын факт гээд 1966 онд батлагдсан. Манайх 1974 онд нэгдэж орсон. Ерөөсөө олон улсын эрх зүйн манай нэгдэж орсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дараах хамгийн чухал баримт бичиг. Хамгийн чухал баримт бичиг. Үүгээрээ бид маш олон үүрэг хүлээчихсэн. Хүнийг нийгэм, соёлын, эдийн засгийн ямар эрхтэй байлгах вэ, ямар үүрэгтэй байлгах вэ, төр ямар үүрэг хүлээх вэ, хүн өөрөө ямар үүрэг хүлээх вэ, нийгэм бүхэлдээ ямар үүрэг хүлээх вэ гээд.

Тэгээд бид нийт 5 удаа тайлан хүргүүлчихсэн. Энэ 1998 онд 3, 2012 онд 4, 2021 онд 5 дахь тайлан дээр давтагдсан

3 тайлан давтагдаад л яриад байгаа юмнуудыг хэлье.

Ингэхээр нөгөө ерөөсөө манай энэ тайлан хэлэлцүүлдэг практик ийм болчихоод байгаа байхгүй юу. Би 1988 онд Гадаад яаманд ажилд ороход тийм л байсан ч, одоо гэсэн ерөөсөө л яг тэр чигээрээ л байгаад байдаг.

Очдог. Цоо шинэ конвенцод нэгдээд орчихсон юм шиг. Өмнө нь ерөөсөө хэлэлцүүлж байгаагүй юм шиг цоо шинэ мэдэхгүй хүмүүс очиж байгаа юм шиг. За, ийм юм болчихлоо, бид ингэчихлээ гээд л нөгөөдхөө ярьдаг.

Тэгэхээр нөгөөдүүл нь толгой сэгсрээд л. Үгүй ээ, одоо боль л доо, Ц.Мөнх-Оргил оо ч гэдэг юм уу, П.Анужин. Бид өмнө нь хэлсэн шүү дээ. 4 жилийн өмнө үүнийг ингэж ингэж засвал яасан юм бэ. Энэ конвенцын заалтыг чинь та нар ингээд хэрэгжүүлэхгүй байна шүү дээ. Үүнийг дутуу хэрэгжүүлээд байна шүү дээ. Одоо үүнийгээ хэрэгжүүл л дээ гээд л зөвлөмж өгдөг.

Тэгэхээр нь тийм байна шүү дээ. За одоо ёстой яг хэрэгжүүлнэ ээ гээд л явдаг. 4 жилийн дараа Ц.Мөнх-Оргил нь ч солигдчихсон, П.Анужин нь ч солигдчихсон. Одоо хэн байдаг юм, Ж.Чинбүрэн, Б.Жаргалмаа хоёр очоод л яг л нөгөөдхөө яриад байдаг.

Нөгөөдүүл нь дахиад л хэлж байдаг. Ингээд л ерөөсөө давтагдаад яваад байгаа нэг ийм процесс байгаа байхгүй юу.

Ерөөсөө энэ дээр нөгөө нэг тийм системтэй, бид тууштай дэс дараатай арга хэмжээ авахгүй.

Энэ дээр хамгийн түрүүнд ингэж хэлж байгаа юм. Факт, түүний нэмэлт

протоколыг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэх шүүгч, прокурор, өмгөөлөгч, иргэний нийгмийн байгууллага, оюутан зэрэг хүмүүсийн фактын талаарх ойлголтыг нэмэгдүүлээч. Энэ факт гэдэг чинь Монгол Улсын хууль, Үндсэн хуультай адилхан шууд хэрэгжиж байх ёстой заалт байтал үүнийг чинь хүн мэдэхгүй байна шүү дээ. Мэдэхгүй болохоор хэрэгжүүлдэггүй.

Хамгийн мэдэж байх ёстой хүмүүс нь Улсын Их Хурлын гишүүд, шүүгч нар. Жишээ нь, одоо юу гэдэг юм эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах Монгол Улсын хууль тогтоомжид нэг заалт дутуу байлаа гэхэд, яг тэр асуудал нь тусгагдаагүй байлаа гэхэд дүүргийн шүүгч, давж заалдах шатын шүүгч манай хуульд байхгүй байна. Гэхдээ манай нэгдэж орсон эдийн засаг, нийгэм, соёлын фактад төдий төдөд нь ингээд заачихсан байгаа.

Тэгэхээр энэ Монгол Улс Засгийн газар ийм үүрэг хүлээчихсэн байна.

Тийм учраас Засгийн газар үүргээ хэрэгжүүлээгүй байна гээд жишээ нь, асуудлыг шийдэж л байх ёстой байхгүй юу.

Энэ ерөөсөө байдаггүй. Яагаад гэвэл тийм конвенцод орсноо л мэддэг болохоос биш яг конвенц нь юугаа заачихсанаа мэддэггүйтэй холбоотой байгаа юм.

Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааг л ерөнхийдөө жоохон тийм сулбагар байна л гэж л олон удаагийн зөвлөмж дээр хэлээд байгаа юм. Тэгээд бид яах вэ хууль тогтоомжоо батлаад л, санхүүгийн нөөц бололцоотой болгоод л яваад байгаа юм.

Тэгэхдээ ялангуяа манай. Ерөөсөө явж явж энэ хүний эрхийн асуудал хамгийн нухацтай яригдах Байнгын хороо бол манай Байнгын хороо байгаа байхгүй юу. Төрийн байгуулалт, Хууль зүйн байнгын хороон дээр улс төр, нийгмийн эрхүүд. Жагсах, цуглах, сонгуульд орох, оролцох, сонгогдох эрхийн асуудлууд. Тэд нар Монголд харьцангуй биелэлээ олоод байгаа байхгүй юу. Улс төрийн шинж чанартай учраас.

Яг энэ нийгэм, эдийн засаг, соёлын эрхүүд нь хаягдчихаад байдаг. Нэг тийм дагавар. Мөнгө байхгүй учраас гээд. Тийм ээ. Төсвийн хөрөнгө байхгүй учраас. Мэдэхгүй учраас гээд.

Гэтэл энэ конвенцын хэрэгжилтийг чинь ингээд нэг нэгээр нь хараад яваад байхаар мөнгө шаардагдахгүй, төсөв шаардагдахгүй зүгээр л ажлын зохион байгуулалт, дэс дараатай, системтэй хэрэгжилт, тэр хэрэгжилтийг шалгадаг Улсын Их Хурлын тууштай үйл ажиллагаа л их шаардагдаад байгаа байхгүй юу.

Тийм учраас манай Байнгын хороо энэ дээр их анхаармаар юм билээ. Ялангуяа Хүний эрхийн Үндэсний Комиссыг илүү яаж шүдтэй болгох вэ гэдгийг хэдүүлээ их бодмоор юм билээ.

Одоо манай Хүний эрхийн Үндэсний Комисс чинь зөвлөмж л өгдөг байгууллага болчихоод байгаа шүү дээ. Тийм ээ. Сая бид хуульд нь өөрчлөлт оруулаад ганц нэг захиргааны актыг түдгэлзүүлэх эрх олгосон байхгүй юу.

Гэтэл энэ Хүний эрхийн Үндэсний Комисс уг нь анх бидний бодож байсан санаснаар яах ёстой вэ гэхээр үндсэндээ омбудсмены буюу шууд шаардлага гарах юм бол зарим хуулийн хэрэгжилтийг

түдгэлзүүлэх саналыг жишээ нь шууд цэцэд оруулаад түдгэлзүүлж байдаг. Хүний эрхийнхээ асуудлаар. Засгийн газарт шаардлага хүргүүлээд Засгийн газрын журмыг шууд өөрөө мэдээд хэрэгжилтийг нь түдгэлзүүлж байдаг гэх мэтийн шүттэй байгууллага баймаар байгаа байхгүй юу. Торгууль тавьдаг ч байдаг юм уу. Тийм ээ.

Тэгэхгүй болохоор зөвлөмж өгөөд л байдаг. Манай Байнгын хороогоор хэдэн удаагийн зөвлөмж хэдэн удаа оров оо. Тэгээд л бид буцаагаад л Засгийн газарт. Үгүй ээ, одоо Засгийн газар аа, үүнийг нь хэрэгжүүлээч ээ л гээд байдаг. Засгийн газар нь бид ажиллаж байна, хөрөнгө мөнгө хүрэхгүй байна гээд. Ингээд нэг энэ комиссын хийж байгаа сайн ажлууд.

Ер нь комисс сайн ажиллаж байгаа юм. Хөөрхий. Өөрийнхөө яг байгаа эрх зүйнхээ хүрээнд зөвлөмжөө гаргаад л, судлаад л, үнэлгээ өгөөд л, ингээд засаач ээ л гээд байдаг.

Түүнд нь одоо юу гэдэг юм, албадах тэр илүү шүд гаргах бололцоо нь байхгүй учраас жоохон зовлонтой байгаад байгаа юм.

Энэ удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх бодитой арга хэмжээ авах гэсэн зөвлөмж гаргаад байгаа юм.

Тэгээд энэ дээрээ болохоор энэ юуг хэлээд байгаа юм шүү, гишүүд ээ. Зөвхөн энэ сонгууль яриад байгаа юм биш шүү. Энэ юуг хэлээд байгаа юм. Бизнесийг бас хэлээд байгаа юм. Бизнес. Өөрөөр хэлбэл одоо энэ дээр ямар зөвлөмж гаргаад байгаа вэ гэхээр энэ төрийн өмчит ч байдаг юм уу, эсвэл хөрөнгийн бирж дээр хувьцаа нь арилжаалагдаж байгаа нээлттэй

компаниуд байна шүү дээ. Энэ ТУЗ-д та нар эмэгтэй хүн оруулж байгаач ээ гэж. ТУЗ-д нь.

Эмэгтэй хүн гэхээр ороод л заавал юу гэдэг юм нийгмийн асуудал яриад бай гэсэн үгүй биш шүү дээ. Тийм ээ. Хайж байгаад яг тэр эрэгтэй хүнтэй адилхан мэдлэг боловсролтой ажлын туршлагатай тийм хүмүүсийг олж илүү түлхэж оруулж байгаач ээ. Тэгэхгүй бол манайх юу гэдэг юм, нөгөө жендэрийн тэгш байдал гэхээр л сонгох, сонгогдох эрх ч байдаг юм уу, ажил, ажлын байр ч гэдэг юм уу тийм юмаар ойлгоод байдаг.

Тэгэхээр олон талтай байгаа юм. Тэгээд энэ дээр хэлээд байгаа юм.

Дараагийн нэг энэ хэлээд, зөвлөөд байгаа юм бол энэ малчдын бэлчээр, усны нөөцийг хамгаалах үүднээс энэ уул уурхайн салбар эрх зүйн орчныг шинэчлэх, холбогдох хуулийн хэрэгжилтэд та нар анхаараач ээ гээд. Энэ бас л олж харж чадаагүй байхгүй юу.

Одоо энэ чинь манайд хойд талын аймгуудаар юу болж байна вэ гэхээр бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан. Газраа булаацалдсан усны нөөцөө булаацалдсан нэг проблем. Жоохон урагшаагаа юм уу уул уурхай дээрээ очихоор бэлчээр, уул уурхайн проблем.

Тэгээд үүнийг мэдээж бид манай Байнгын хороо ч юм уу, Засгийн газар нэг бүрчлэн шийдээд байх юу гэдэг юм тийм зөвлөмж өгөөд байгаадаа биш. Эрх зүйн орчныг нь ойлгомжтой болгооч ээ л гээд байгаа байхгүй юу.

Өөрөөр хэлбэл бэлчээр гэж яг юугаа хэлэх юм, яаж өмчлүүлэх юм, өмчлүүлэхгүй бол яаж ашиглуулах юм, хэн нь ямар эрх, үүрэгтэй байх юм гэдгээ ойлгомжтой болгоод энэ бэлчээртэй

холбогдсон маргаанудаа нэг тийшээ болгооч ээ гэсэн зөвлөмжүүдийг хэлээд байгаа юм.

Дараагийнх нь, энэ их чухал асуудал байгаа юм. Энэ манай Байнгын хороо их онцгой анхаарах ёстой зүйл бол. Энэ албадан нүүлгэн шилжүүлэлт, гэр хорооллын дахин төлөвлөлтөөс шалтгаалж албадан нүүлгэх эрсдэлтэй тулгарч буй оршин суугчдын гомдлыг шийдвэрлэх, хамгаалах, зохих хууль зүйн хамгаалалт бий болгох, өртсөн хүмүүсийг орон байртай болгох, бусад боломжийг баталгаажуулах гээд.

Энэ олон улсын байгууллагуудад зөндөө гомдол очдог юм байна л даа. Бид мэддэг мэддэггүй. Тэгээд л эд нар чинь өөрсдөө манай интернэт, шүүхийн практикийг судлаад манай тайланд ч гэсэн энэ асуудал тусгагдаж байдаг.

Тэгээд энд манай Байнгын хороо нэг анхаарах ёстой асуудал бол энэ Газрын багц хууль Засгийн газраас өргөн баригдаад энэ газар албадан шилжүүлэх, албадан чөлөөлөх хууль өргөн барьчихсан байгаа байхгүй юу.

Тэгээд энэ дээр манай Байнгын хороо их идэвхтэй оролцож, тэр хүн өөрт нь байгаа алга дарам газрыг Үндсэн хуулиараа ч гэсэн тийм, хуулиараа ч гэсэн тийм Засгийн газар тэр хүнд тодорхой хэмжээний тэр үнэ өртгийг нь бүрэн төлөөд алдагдалгүй болгоод газрыг нь төрийн байдалд авах эрхтэй л дээ.

Тэгэхдээ ингэж авахдаа тэр хүмүүсийг хохироохгүй байх, эдийн засгийн болон нийгмийн эрхийг нь хохироохгүй байх бүрэн тэр алдагдсан өмчөө нөхөж авах өөр хэлбэрээр хангаж өгөх асуудал аягүй чухал байгаа байхгүй юу.

Тэгээд энэ хууль болтол Эдийн засгийн байнгын хороон дээр хэлэлцэгдээд байгаа юм.

П.Анужин дарга аа, тэр хуулийг татаж аваад яг тэр иргэдийг хамгаалах эрхийг нь хамгаалах талаас нь манай Байнгын хороо зөвлөмжүүдээ өгвөл өгмөөр юм билээ.

Жишээ нь, ийм юм байгаа байхгүй юу. Ерөөсөө нэг талаас үнэлгээний асуудал.

Гэхдээ үнэлгээний асуудлаас гадна тэр чинь олон нарийн асуудлууд байгаа байхгүй юу. Тэр хүнд яаж мэдээлэл өгөх юм, хэзээ өгөх юм, хэдэн сарын өмнө өгөх юм, яаж ажил амьдралаа зохицуулах арга замыг нь гаргаж өгөх юм. Тэр хүнд өөр ямар дэмжлэг туслалцаа үзүүлэх юм. Тийм ээ. Газрыг нь үнэлэхээс гадна.

Жишээ нь, манай Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороонд замын урд, хойно хоёр төсөл хэрэгжиж байгаа байхгүй юу. Нэг нь Азийн хөгжлийн банкны төсөл. Тэнд нь Азийн хөгжлийн банкны журмаар газар чөлөөлж байгаа юм. Хот Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийж байгаа учраас Азийн хөгжлийн банкны баталчихсан яг энэ журмаар л газар чөлөөлнө шүү. Энэ журмаас өөрөөр газар чөлөөлчихсөн байх юм бол бид зээлээ өгөхгүй шүү гэгчхэж байгаа юм.

Тэгэхээр яг тэр журмаар нь чөлөөлөхөөр иргэд өө тэгье тэгье, өндөр ч өртөгтэй юм байна, бололцоотой ч юм байна, ТҮЦ-ийг ч үнэлчхэж байна, үүнийг ч үнэлчхэж байна, худгийг ч үнэлчхэж байна бид өгчихье гээд хөрөнгө мөнгөө аваа, нөхөн төлбөрөө аваад газраа чөлөөлөөд явчхаж байгаа юм.

Хойд талд нь болохоор хотоос хэрэгжүүлж байгаа төсөл. Хотын манай бид нарын баталсан хуулийн хүрээнд хот өөрөө баталсан журмаараа газар чөлөөлж байгаа байхгүй юу.

Тэнд нь ерөөсөө газар чөлөөлөгддөггүй. Иргэд чөлөөлдөггүй. Яагаад вэ. Яагаад гэвэл миний хөрөнгийг дутуу үнэлчихсэн. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ийм ийм ийм маргаантай гээд маш олон маргаантай асуудлууд байгаад байна.

Тэгэхээр үүнийг бүгдийг нь нэгтгэж бид нэг талаас хүний эрхийн асуудлыг нь, хөрөнгө, өмчөө хамгаалах асуудал, баталгаажуулах асуудал байна. Нөгөө талаас энэ хот төлөвлөлтийн асуудал ч гэсэн энэ дээр ерөөсөө очоод гагцхиаад байна шүү дээ. Тийм ээ. Энэ дээр бид их анхаармаар юм билээ.

Хамгийн сүүлд нь энэ их чухал асуудлыг бас эд нар ингээд гурван зөвлөмж буюу 12 жил дараалан бид нарт өгөөд байгаа байхгүй юу. Энэ ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийг. Тэр дундаа хөдөө орон нутаг болон бүх ерөнхий боловсролын сургууль баталгаажуулах гэж.

Ийм зөвлөмж өгөөд байгаа байхгүй юу. Хүүхдүүдээ хоолтой болгох чухал. Тэгэхдээ цэвэр ундны устай байлгаач ээ. Сургууль болгон дээр үнэ төлбөргүй ус уудаг тийм бололцоо бүрдүүлж өгөөч ээ. Усгүйжилт гэдэг чинь хүүхдийн оюуны болон бие бялдрын хөгжлийг хамгийн их хохироодог **dehydration**^[шингэн алдалт] л битгий болгооч ээ л гэж зөвлөөд байгаа байхгүй юу.

Тэгээд Ерөнхий боловсрол сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль гээд бид хууль

баталсан шүү дээ. Тэр сургуулийн хүүхдийн хоол.

Түүн дээр бид уг нь хуульд нь маш тодорхой заачихсан юм. Монгол Улсад ажиллаж байгаа 865 улсын болон хувийн сургуулиудад бүгдэд нь үнэ төлбөргүй цэвэршүүлсэн устай болгооч ээ гэж. Ус болго гээд бид Засгийн газарт хугацаатай үүрэг өгчихсэн юм.

Тэгсэн сая КОВИД болоод, хоёр жил болоод энэ ажил ингээд хоёр жилээр хойшлогдож байгаа юм.

Ер нь Засгийн газар үүнийг 2025 оны 01 сарын 01-нээс хэрэгжүүлэх ёстой юм.

Энэ дээр жишээ нь, манай Байнгын хороо их анхаарах ёстой болчихоод байгаа байхгүй юу. Тийм ээ.

Хүүхэд хоолтой байх чухал. Тэгэхдээ хоолноос илүү чухал хүүхдэд ус хэрэгтэй байгаа байхгүй юу. Гүйнэ, харайна, тийм ээ, хөлс нь гарна. Тэгээд л өдөржингөө сургууль дээрээ усгүй байчихаар хатингшраад биеийн хөгжил оюуны хөгжилд нь нөлөөлөөд байгаа байхгүй юу.

Энэ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж шүү дээ. Зөвхөн энэ юунуудын зөвлөмж биш.

Гэх мэтээр маш олон дэс дараатай зөвлөмжүүд байгаа юм.

Дараагийн юу нь Хүүхдийн эрхийн тухай конвенц дээр би хоёрхон санаа хэлчихье.

Ингээд нэг конвенцын заалт бүрээр нь яриад байх юм бол энэ ерөөсөө маш олон зүйл гарна.

Тэгэхээр дөрвөн Байнгын хороогоор 30 конвенцоо хэрэгжүүлээд дуусахаар би өдий зэрэгтэй зузаан ийм Их Хурлын тогтоолын төсөл гарах болов уу гэж бодож байгаа юм.

Конвенц болгоных нь зөвлөмж болгоноор нь Засгийн газарт хэдүүлээ үүрэг өгмөөр байгаа юм. Хуулийн төсөл өргөн барь гэж.

Өргөн барихгүй өөрсдөө өргөн барихаар.

Энэ дээр Хүүхдийн эрхийн конвенц дээр хоёр чухал санаа хэлээд байгаа юм. Тэр унаач хүүхдийн асуудал, гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг түрүүн ярьчихсан.

Энэ Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөө та нар янзлаач ээ гээд. Энэ дээр ерөнхий санаа нь юу гэж хэлээд байгаа вэ гэхээр ингээд байгаа байхгүй юу.

Гэр бүлийн хууль гэдэг байна шүү дээ ерөөсөө өмчийн хууль байгаа байхгүй юу. Эрхийн хууль. Өмчийн асуудал.

Энд гэр бүл тогтвортой байна, аав ээж нь хүүхдээ зодож болохгүй ч гэдэг юм уу. Тийм ээ. Эсвэл тэр тухай биш байгаа байхгүй юу. Тэр чинь Эрүүгийн хуулиараа явчихна. Тийм ээ. Сайн дураараа гэрлэнэ гэдэг чинь ойлгомжтой.

Энэ ерөөсөө өмчийн асуудал яригдаад байгаа юм.

Гэр бүл болохоор. Одоо бид чинь суурин амьдралд шилжчихлээ шүү дээ. Бүгдээрээ эрэгтэй, эмэгтэйгүй өмч хөрөнгөтэй байна.

Ингээд гэр бүл болохоор эрэгтэй, эмэгтэй хоёр хүний өмч ямар нь дундынх

болох юм, яаж хоорондоо тохиролцох юм, аль нь тус тусдаа өөрийнхөө хөрөнгөтэй байх юм. Саллаа сарнилаа гэхэд үүнийг яаж зохицуулах юм. Саллаа сарнилаа гэхэд тэр хүүхдэд ямар өмч хөрөнгө үлдэх ёстой юм. Тэр өмчөөс хүүхэд яаж эрхээ хамгаалуулж үлдэх ёстой юм гээд энэ асуудлууд нь хоцорчхоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ талаас нь янзлаач ээ гэж зөвлөмж өгөөд байгаа юм.

Өнөөдөр манайд энэ ерөөсөө байдаггүй. Тэгээд л нөгөө өмчийн маргаан. Тийм ээ. Хэрүүл уруул чинь ерөөсөө эндээс л яваад байгаа байхгүй юу.

Манай зохицуулалт болохоор Иргэний хуульд ерөнхий зохицуулалтууд байгаад байдаг. Ерөнхий. Яг гэр бүлийн харилцаанд ороод явчихаар гэр бүлийн харилцаа чинь нарийн, энэ нийтийн эрх зүйгээсээ илүү хувийн эрх зүй чинь бүр нарийн нарийн хөрөнгө мөнгөтэй холбоотой учраас үүнийгээ янзлаач ээ гэдэг зөвлөмжийг өгөөд байгаа юм.

Тэгэхээр би Байнгын хорооныхондоо ямар санал хэлэх гээд байна вэ гэхээр энэ Гэр бүлийн хуулийг үндсэн хэлэлцэх Байнгын хороо нь Хууль зүйн байнгын хороо юм билээ.

Бид хамтраад, хамтарсан ажлын хэсэг гаргаад ийшээ ормоор юм байна лээ.

Тэгээд болж өгвөл одоо энэ бүрэн эрхийн үлдсэн жил хагасын хугацаанд манай Байнгын хороо Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулгыг хийчхээд дараагийн сонгуульдаа орох юм бол энэ олон хүнд их буян болох чухал хууль байгаа юм.

Хүмүүс бодохдоо болохоор Гэр бүлийн хууль гэхээр л Монгол гэр бүлийг л салгадаггүй, бат бэх байдаг. Тийм ээ. Ийм л болгох тухай бодоод байгаа юм. Үгүй л дээ. Тэр өөрөө нийгмийн тусдаа процесс учраас тэр тусдаа нийгмийнхээ хуулиар явна.

Бидний үүрэг бол, хууль тогтоогчийн хувьд энэ гэр бүлийн өмчийн харилцааг л энэ юугаар нарийвчилж зохицуулж өгөх асуудал байгаа юм.

Энд Хүүхдийн эрхийн конвенц дээр хэрэгжүүлчихсэн маш олон юм байгаа юм.

Тэгээд үүнийгээ тайландаа бид тэр болгон гүйцэд тусгаж өгч чадахгүй байгаа учраас миний бодлоор нөгөөдүүл ингээд нэхээд байгаа юм. Жишээ нь, хүүхдийг сэтгэл зүйгээр тусгайлсан мэргэшсэн сэтгэл зүйчийн үйлчилгээр хангаж байгаач ээ гээд.

Тэгтэл бид бүх сургуулиуддаа сэтгэл зүйчтэй болгочихсон шүү дээ. Хүүхдийн өдрийн хоолтой болчихсон, сургууль болгон сувилагчтай болчихсон. Эмчтэй байна гэх мэтийн хэрэгжүүлчихсэн давуу талууд их байгаа юм.

Хүүхдийн эрхийн конвенцын зөвлөмжүүд гэвэл ингээд 17, 18 хуудас байгаа юм. Энэ дээр нэг нэгээр нь яриад явах юм маш их хэмжээний цаг гарна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц гэж 2006 онд батлагдсан. Монгол Улс 2012 онд нэгдээд орчихсон ийм чухал конвенц байгаа юм. 2006 нэгдээд орчихсон ийм чухал конвенц байгаа юм.

Тэгээд энэ энд их олон асуудлууд бий. Тэгэхдээ энэ дээр би зүгээр хоёр л юман дээр анхаарал хэлчихье гэж бодсон юм. Өөрөөр хэлбэл бид дотоодын хуульдаа батлахдаа ч гэсэн, олон улсын гэрээ конвенцод нэгдэж орохдоо ч гэсэн яг хэрэгжилт нь Монголын нөхцөлд яг яаж таарч байна, юуг өөрчлөх хэрэгтэй байна гэдэг дээр их бодож байх ёстой байгаа юм. Жишээ нь, энэ зөвлөмж нь ингэчихсэн байгаа байхгүй юу. Оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийг албадан эмнэлэгт хэвтүүлэх, институтэд байлгах.

Нөгөө институционализац гээд байгаа шүү дээ. Тийм ээ. Манайхаар Шархаданд байлгах гэх мэтээс хамгаалах хуулийн хамгаалалт Үндсэн хуулиас өөр хангалттай байхгүй байна гэж байгаа юм.

Энэ чинь олон улсын гэрээ конвенцоороо бид нарт юу гэж үүрэг хүлээчихсэн бэ гэхээр өөртөө болон бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учруулахгүй л бол тэр хүнийг албадан эмчлэх болохгүй байгаа байхгүй юу.

Өөрөө болон бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учруулаад байх юм бол тэр хүнийг албадан эмчлэхээс өөр арга байхгүй.

Гэтэл энэ ялгааг манай хууль тогтоомжид гаргаж өгөөгүй. Манай хуульд бүр юугаа тусгачихсан гэхээр зүгээр ингээд биччихсэн. Сэтгэцийн эмгэгтэй хүнийг эмнэлэгт албадан эмчлэх гээд. Бүр ялгаагүйгээр бүр эсрэгээрээ. Нөгөө конвенц нь болохгүй шүү гээд байхад сэтгэцийн эмгэгтэй хүнийг албадан эмчилнэ шүү гээд бүр хуульдаа заачхаж байгаа юм.

Тэгэхээр үүнийг одоо жишээ нь, бид яаралтай засаад, ямар тохиолдолд, ямар эмчийн акттайгаар, ямар эмчийн

зөвлөмжтэйгөөр, ямар шүүхийн шийдвэртэйгээр албадан эмчилж байх ёстой юм бэ гэдгийг нарийвчилж өгөх ёстой болчхоод байгаа байхгүй юу. Гэх мэтийн.

Ер нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах конвенцын хэрэгжилт дээр манай Байнгын хороо бүр тусад нь нэг жижигхэн ажлын хэсэг гаргаад энэ конвенцын хэрэгжилт, хуулийн хэрэгжилтийг бүр нэг жич үзмээр юм билээ.

Ер нь энд хөрөнгө зарагдаад байдаг. Улсын төсвөөс хөрөнгө гараад байдаг. Олон улсын байгууллагаас тусламж ирээд байдаг. Гэтэл тэр нь яг хүндээ очиж байна уу, үгүй юу гэдгийг бид үзэх ёстой байгаа байхгүй юу. Тийм ээ.

Тэгэхгүй ингээд л тайлан нэхдэг. Тайлан дээрээ ингэчихсэн, тэгчихсэн, тэгээд журам баталчихсан, энэ болчихсон, Засаг дарга ийм үүрэг авчихсан гээд байдаг.

Гэтэл нөгөө үүрэг авсан хорооны Засаг дарга нь, багийн дарга нь яг тэр нь хэрэгжиж байгаа юм уу, хэрэгжихгүй байгаа юм уу, яг тэр эмчилгээ нь үр үр дүнтэй байгаа юм уу, үр дүнгүй байгаа юм уу, зарсан мөнгө нь хүндээ очиж байна уу, үгүй юу гэдгийг бид нэг бүр газар дээр нь очиж нэг харах ёстой болчхоод байгаа юм.

Тэгэхгүй бид засгаас нэг тайлан авдаг. Засаг нь яамнаасаа тайлан авдаг. Яам нь Засаг дарга нараас тайлан авдаг. Тэгээд л ерөөсөө ингээд л дээш дээшээгээ цаасан тайлан болчхоод амьдрал дээр хэрэгжиж байна уу, үгүй юу гэдгийг нэг гарцаагүй үзэх хэрэгтэй болчхоод байгаа юм.

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилт байгаа. Энэ дээр ингээд нарийвчилсан маш олон заалтуудтай үүнийг гишүүдэд бүгдэд нь ингээд тараагаад өгчихсөн учраас та нар өөрсдөө харчих байх.

Энэ дээр энэ олон улсын байгууллагаас өгч байгаа ерөнхий дүгнэлт нь юу гэж байгаа вэ гэхээр бусад орнуудтай харьцуулахад боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломж маш өргөн байна. Хуулиар хориглосон зүйл алга байна.

Зүгээр зөвлөж байгаа юм нь бол энэ ажлын байран дахь бэлгийн дарамт дээр их анхаарч Тийм ээ. Энэ хууль хяналтын байгууллагууддаа илүү сургалт явуулж, төрийн бус байгууллагуудын дэмжлэгтэйгээр энэ ажлыг илүү системтэй болгох хэрэгтэй байна гэдэг зөвлөмж өгөөд байгаа юм.

Зүгээр энэ дээр нэг манайд анхааруулж хэлээд байгаа юм бол ялангуяа хөдөөгийн эмэгтэйчүүдийн боловсролын асуудал.

Тэгээд бусад улс орнууд тэгдэг юм байна л даа. Жоохон эдийн засгийн байдал хүндрээд л ирэхээр охидуудаа сургуулиас гаргачихдаг юм байна л даа.

Тэгэхээр ийм юм танайд байхгүй байна. Гэхдээ ийм юм гарах вий дээ. Болгоомжилж байгаарай л гэсэн зөвлөмжүүд өгч байгаа юм.

Тэгээд үүнийг би та нарт бүгдийг нь нарийвчлаад тараачихсан байгаа.

Эцэст нь, Албадан хөдөлмөрийн конвенц дээр ойлгомжтой.

Энэ дээр хоёр зөвлөмж өгч байгаа юм.

Энэ цэргийн хөдөлмөр эрхлэлт гэдэг чинь хуультай шүү. Гэрээ, конвенцтой шүү. Цэргээр огт ажил хийлгэхгүй гэсэн конвенцын заалт байхгүй шүү дээ. Цэрэг хүнээр ажил хийлгэж болно. Гэхдээ ямар нөхцөлтэй, ямар журамтай ажил хийлгэх вэ гээд конвенц заачихсан байгаа. Тэрийгээ баримтлаарай.

Хоёрдугаарт, ялтны хөдөлмөрийг хувийн секторт ашиглаж болохгүй шүү гэсэн заалттай. Үүнийг нь сая бид 2021 онд баталсан Хөдөлмөрийн хуулиараа маш дэлгэрэнгүй салгаад өгчихсөн байгаа.

Товчхондоо ийм байна. Тэгээд бусад дөрвөн Байнгын хороогоор зөвлөмжийн хэрэгжилтийг нэг бүрчлэн 30 конвенцоор нь хэрэгжээд ирсний дараа Улсын Их Хурлын Засгийн газарт үүрэг өгөх чиглэлүүдийг бүгдийг нь тусгасан ийм том тогтоолын төсөл Байнгын хорооны гишүүдэд тараана.

Тэгэхдээ тэр үед Байнгын хорооны гишүүд саналаа нэмэрлээрэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Монгол Улсын олон талт олон улсын гэрээ, гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тухай тайланг Цэндийн Мөнх-Оргил гишүүнд тавилаа.

Ц.Мөнх-Оргил гишүүнд баярлалаа.

Тайланг Байнгын хорооны бүх гишүүдэд дэлгэрэнгүйгээр тараасан байгаа.

Ингээд тайлантай холбоотойгоор асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя.

Үг хэлэх гишүүдийн нэрсийг Сайнхүүгийн Ганбаатар гишүүнээр тасаллаа. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Бид чинь ерөөсөө анзаардаггүй юм байна. Энэ талаар огт мэдээлэл байхгүй юм байна л даа.

Энэ бол анх удаа ингэж нэгтгэж байгаа юу? Энэ тайланг. Ер нь нэгтгэж гаргаж байгаа юу?

Тэгээд өнгөрсөн хугацаанд нийтдээ Монгол Улс 294 олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэж орсон юм байна. Түүнээсээ тайлангаа өгдөг 30-ийнх нь тайлан гэж тэнд хэрэгжилтэд нь тайлан гаргаж байгаа юм байна.

Ерөнхий дүгнэлтийг нь хийхээр ерөнхийдөө л манай улсын олон улсын гэрээ, конвенцод нэгдсэн үүргээ сайн хангалтгүй биелүүлдэг иймэрхүү л юм харагдаж байх шиг байна.

Нөгөө талаар таны энэ нийтлэг дутагдал дээр энэ олон улсын гэрээний хэрэгжилтийн мэдээллийн нэгдсэн сан байхгүй гэдэг чинь өөрөө аюултай асуудал байна шүү дээ.

Ерөөсөө энэ асуудлуудыг нэгтгэсэн мэдээллийн. Хаана ямар гэрээ, конвенц явж байгаа юм гэдгийг яамд ямар ч уялдаа холбоо байхгүй. Засгийн газар дээрээ нэгдсэн мэдээллийн сан байхгүй гэдэг чинь өөрөө асуудал дагуулж байгаа юм биш үү?

Тийм учраас цаашдаа 294 гэрээ, конвенц. Тэгээд тайлангаа жил болгон хүргүүлдэг 30 гэрээ, конвенцын хэрэгжилтийг нэгтгэсэн мэдээллийн сан байхгүй гэхээр.

Тэгэхээр энэ дээр цаашдаа мэдээллийн сантай болохгүй бол таны түрүүний хэлдгээр төрийн албан хаагчдын хүний нөөцийн асуудал чинь өөрөө тогтворгүй байгаа нь үнэн учраас, энэ мэдээллийн сан байхгүй байгаа учраас ингээд үндсэндээ бүртгэл, судалгаа хангалтгүй, уялдаа холбоо байхгүй гэдэг чинь үүнээс үндэслэлтэй байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр онцгой анхаарал хандуулах ёстой юм байна гэж би хувьдаа бодож байна.

Нөгөө талаар энэ орон нутаг, анхан шатад төрийн албан хаагчдыг судалгаа юмаар дардаг, ажлын ачааллыг нэмэгдүүлдэг зүйл чинь ерөөсөө энэ шүү дээ бас. Энэ олон гэрээ конвенцын баахан л тайлан ирүүл гээд. Орон нутагт энэ төрийн албан хаагчид чинь ерөөсөө тайлангаас тайлангийн хооронд.

Иргэдэд нөгөө төрийн үйлчилгээ үзүүлэх ажил дээрээ анхаарал хандуулахаас илүүтэйгээр баахан л дээшээгээ Засгийн газар, яам, агентлагт тайлан, судалгаа өгдөг.

Энэ багш нарыг ч хүртэл ер нь сүүлийн үед Боловсролын яам анхаарах хэрэгтэй юм шиг байна лээ. Багш нар чинь үндсэн хичээлээ заахаасаа илүүтэйгээр хамаг цагаа энэ тайлан, мэдээлэлд дарагдаад л явж байх жишээтэй. Эмч нар мөн адилхан гээд ингээд.

Тийм учраас цаашдаа энэ олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг Засгийн газрын түвшиндээ яамдаас доош гэдэг юм уу, энэ тайлан мэдээллүүд дээр дардаг байх асуудал нь хэр зохимжтой юм бол доо. Цаашдаа яамдууд л гол бодлогоо бариад, тайлан юмаа нэгтгээд

өгөөд ингээд явчихдаг байх нь дээр юм биш үү гэж.

Ер нь тэгээд таны дүгнэлтээр манай улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ хэр биелүүлж байна гэж үзэж байна вэ? Ярьсан хэлсэндээ байна уу? Өөрсдийн хийнэ гэсэн чиг үүргээ хэрэгжүүлж чадаж уу? Энэ гэрээгээрээ.

Ерөнхий дүгнэлт дээр нэг ийм асуулт л асууя.

Цаашдаа тэгээд хэрэгжүүлж чадахгүй байгаа. Хүлээчихсэн хэр нь ээ хэрэгжүүлж чадахгүй байгаа ийм гэрээ конвенц байна уу? Засаж сайжруулах ёстой юм байна уу?

Тухайлбал, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ярьж байхад цаазын ялгүй байх тэр гэрээ конвенцод нэгдчихсэн гэж би ойлгож байгаа. 55 улс орны нэгдсэн.

Гэтэл иргэд чинь болохоор энэ цаазын ялыг сэргээх ёстой гэж яриад байдаг. Гэх мэтчилэн ард иргэдийн болоод төрийн байгууллагуудын хоорондын мэдээллийн зөрүүтэй гэдэг юм уу, энэ байдлаас болоод зөрчилдөөд байгаа гэдэг юм уу ийм асуудал байна уу?

Цаашдаа гэрээ конвенцоос гадна.../минут дуусав/

П.Анужин: Цэндийн Мөнх-Оргил гишүүн хариулья.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа.

Монгол Улсын нэгдэж орсон олон улсын гэрээ, конвенцуудын нэгдсэн сан нь байгаа юм.

Тэгээд ийм ийм юманд нэгдээд орчихсон гэдэг нь байгаа байхгүй юу. Тэр нь Хууль зүйн яаман дээрээ ч байгаа, Гадаад харилцааны яаман дээр ч байгаа юм.

Юуны нэгдсэн сан байхгүй байна гэхээр энэ нэгдэж орсон гэрээ, конвенцуудын хэрэгжилтийн тайлан, хэрэгжилтийг тайлагнасан, бидний тайланд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт гээд. Нөгөө цаашаа өрнөсөн ажил байна шүү дээ. Тийм ээ. Тэрнийх нь нэгдсэн тайлан байхгүй байгаа байхгүй юу.

Жишээ нь, одоо юу гэдэг юм эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхаас хамгаалах олон улсын гэрээ конвенцын хэрэгжилтийг ингээд нэг удаа бид юу гэдэг юм 1998 онд юм уу, 2002 онд ингээд тайлан тавьчихаж байгаа байхгүй юу. Тэгтэл яг юугаа хэлчихсэн юм. Тэрийг нь яг яаж хэрэгжүүлчихсэн юм. Хаанаа очоод гагцчихсан юм гэдэг юм нь тэндээ үлдчихсэн.

Дараагийн хүн нь ч мэддэггүй, тэрний дараагийн хүн нь бүр мэддэггүй.

Тэгэхээр одоо үүнийг бүгдийг нь нэгтгэж авах ажлыг бид дэд ажлын хэсэг дээрээ яриад ер нь бэлтгэл ажлыг нь эхэлчихсэн. Гадаад харилцааны яаман дээр энэ санг нь нэгтгэх ёстой юм билээ.

Тэгээд өөр өөрсдийнхөө гэрээ конвенцын хэрэгжилтийг нэмээд нэмээд яваад байдаг. Пасс кодоор ороод энэ бол ингэж хэрэгжиж байгаа юм байна, энэ нь ингэж хэрэгжихгүй байгаа юм байна гээд тал талаасаа яадаг ийм нэгдсэн сантай болох нь гарцаагүй.

Тэгж байж одоо нөгөө хүнээс шалтгаалахгүй. Нэг ажилтан ирээд солигдоод явчихлаа гэхэд дараа нь нөгөө нэгдсэн сан руугаа ороод л ийм юмтай

байсан юм байна, ийм дараалалтай байсан юм байна, энэ нь хийсэн, энэ нь хэрэгжээгүй юм байна гэдгээ мэддэг болох ажил чухал байгаа юм.

Үүнийг хэрэгжүүлэхэд манай Их Хурал бас их чухал үүрэгтэй юм билээ. Их Хурал энэ тайлангуудыг байнга сонсдог болох ёстой юм билээ.

Байнгын хороогоороо суугаад л өөр өөрсдийнхөө хариуцсан тайлангуудыг сонсоод байхад л энэ чинь их том тийм нэгдсэн сан бүрдэж байгаа байхгүй юу.

30 конвенц дээр Ц.Сандаг-Очир гишүүн ээ, төрийн албан хаагчдыг дарах юм бол ерөөсөө байхгүй. Жишээ нь, Боловсролын яам багш нарыг тэр тайлан мэдээгээр дараад байна шүү дээ. Тийм ээ.

Тэнд ЮНЕСКО-д нэгдэж орсон гэрээ конвенцын хэрэгжилтийг тайлагнуулах гээд багш нарыг тэнд бичгээр дарж байгаа юм ерөөсөө байхгүй.

Яг таны хэлдгээр багш нарыг Нийслэлийн боловсролын газар нь ч байдаг юм уу, аймгийн боловсролын газар нь. Аймгийн боловсролын газарт нь дээрээс нь яам нь үүргийг нь өгчихдөг. Яамнаас нь Засгийн газар.

Тэгээд ингээд энэ конвенцтой конвенцгүйгээр дарчхаад байгаа байхгүй юу. Үүнийгээ болиулах хэрэгтэй. Одоо бид Боловсролын хууль дээр яг тийм заалт орчихсон явж байгаа юм. Багш бол багшаа л хийе.

Ингэхийн тулд манайх жишээ нь, зөвхөн сургууль дээрээ гэхэд бусад орнууд шиг сургуулийг дотор нь хоёр хуваах ёстой юм билээ. Сургалтын байгууллага. Сургууль чинь дотроо хоёр байгууллага байна шүү дээ.

Нэг нь сургалтын байгууллага эрхэлдэг, сургалтаа хийж байдаг. Нөгөөдөх нь захиргааны байгууллага гэж тусдаа байгаа байхгүй юу.

Гэтэл манайх чинь багш, захиргаа хоёр нь хоёулаа нийлчхээд холилдоод багш нь захиргаагаа ч хийгээд байдаг, сургалтаа ч хийгээд яваад байдаг. Үүнийг бүр тусад нь салгамаар юм байна лээ.

Тэгээд сургуулийн захиргааны байгууллага том болмоор юм байна лээ. Хүчтэй болмоор юм байна лээ. Өөрийн хүний нөөцтэй, мэдээллийн сантай, харилцах холбоотой.

Тэгээд тэр нь зөвхөн захиргаагаа л хийгээд явж байдаг. Багш нь зөвхөн сургалтаа хийгээд явж байдаг. Тэр ер нь хэр биелүүлж байна вэ гэдэг дээр бүхэлдээ манай улсад ингээд 1-ээс 5 гэдэг дүн тавих юм бол Монголчууд бид 4 хагас гэсэн дүнтэй явж байгаа юм байна гэж ойлгож байгаа юм. 4 хасах.

Өөрөөр хэлбэл тийм муу гэсэн үг биш. Ингээд бид энэ ажлыг хийж байх явцад нөгөө бусад орнуудыг. Манайхтай асуугаад байгаа юмыг нь бусад орнуудыг ер нь яадаг юм гээд ингээд үзэхээр манайхаас илүү, жишээ нь, Голландыг би сая хуралд явж байхдаа нэг хурлын завсраар орсон чинь Голландын хүчээр алга болгох гэрээний хэрэгжилтийг Голландын Засгийн газар яаж хэрэгжүүлж байгааг асууж байна л даа.

Би тэгээд 30 минут орж суулаа. Тэнд ерөөсөө бүр Голланд мэдээж хууль тогтоож бүх юмаа номоор нь хийчихсэн байгаа байхгүй юу. Гэсэн ч гэсэн л нөгөөдүүлийг чинь ингээд л шахаад л асуугаад л.

Тэгэхээр энэ зөвхөн Монголыг ингээд байгаа юм биш. Дэлхийд бүх улс орнууд.../минут дуусав/

П.Анужин: Баярлалаа. Бадарчийн Жаргалмаа гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Үнэхээр маш сонирхолтой. Бидний хийж хэрэгжүүлэх маш олон ажил байна шүү гэдгийг сануулсан ийм тайлан байна.

Тэгээд нийтдээ 294 олон талт олон улсын гэрээг соёрхон баталсан. Тэр дундаа хүний эрхийн 48 гэрээ, конвенцод Монгол Улс нэгдэн орсон хэдий ч өнөөдрийн байдлаар бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ ялгаварлан гадуурхах, алагчлах энэ байдал байсаар байгаа нь яг өнөөдрийн амьдрал дээр байгаа.

Хэдийгээр бид хуулийн заалтууд, хууль, тодорхой бие даасан хуультай боловчиг өнөөдрийн хэрэгжилт хангалтгүй байгаа гэдэг дээр олон улсын дүгнэлт энэ дээр маш тодорхой бичигдсэн байна.

Зүгээр энгийнээр аваад үзэх юм бол Хөдөлмөрийн тухай хуулийн 44 дүгээр заалт санаж байна. Тийм ээ. 25 ба түүнээс дээш ажилтантай албан байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч ажиллуулах ёстой гэдэг энэ заалт маань өнөөдрийг хүртэл хэрэгжихгүй байгаа.

Төрийн алба болон хувийн хэвшлийнхэн тодорхой хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах энэ үйл явцыг тодорхой хэмжээнд амжилттай биелүүлж байгаа.

Төрийн албанд 50 хувьд ч хүрэхгүй байгаа. Зөвхөн сан бүрдүүлэлтэд хэдэн төгрөг өгөхөөс

илүүтэй гарч хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ ажлын байраар хангаж чадахгүй байгаа энэ цаг мөчид бид бас үнэхээр эргээд бусад хуулиудаа эргэн харах, хуулийн хэрэгжилт дээр хяналт тавих зайлшгүй шаардлага байгаа гэдэг нь энэ тайлан дүгнэлт нь харагдаж байна.

Үнэхээр Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ ялгаварлан гадуурхдаг уу гэвэл ялгаварлан гадуурхдаг.

Өнөөдөр гэхэд л зүгээр харах юм бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань Улаанбаатар хот, нийтийн эзэмшлийн гудамж талбайдаа явах эрх нь хангалтгүй байгаа. Гийтийн тээвэртээ сууж чадахгүй байгаа энэ нөхцөл байдал байсаар байгаа.

Хэдийгээр түрүүн бид бас тайлан мэдээлэл дээр төсөв дээр бид тодорхой хэмжээнд ингээд ярьж хэлэлцэж байгаа боловчиг зөвхөн халамжаараа бид энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ хүрч үйлчилсэн ажлыг үзүүлэх нь хангалтгүй юм.

Хэдийгээр бид асаргааны мөнгөө нэмж байгаа боловчиг иргэдээ тэр эргээд тэр иргэдээ нийгмээс гадуурхахгүй байх, нийгэм дундаа байлгах тэр боломжийг нь хангаж өгөх ёстой.

Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Ахмад настны тухай хууль болон Асаргаа халамжийн тухай хууль дээр хяналт тавих ажлын хэсэг ажилласны үр дүнд тодорхой хэмжээнд бид ахмадуудад чиглэсэн тэтгэвэр нэмэх тэр бодлогыг бий болгож чадсан.

Эргээд халамж асаргаанд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмадуудынхаа халамжийн мөнгийг тодорхой хэмжээнд нэмүүлсэн ийм үр үр дүн гарсан.

Тэгэхээр энэ үр дүнгээ бид улам бүр ахиулах зайлшгүй шаардлага үүсээд байгаа. Өнөөдөр Шархаданд хэвтүүлээд өгөөч ээ. Хүүхдээ бид харж чадахгүй байна. Манай аав ийм хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн өвчтэй юм үүнийг хэвтүүлээд өгөөч ээ гэдэг хүсэл маш ихээр ирдэг.

Гэтэл яг үнэхээр бид энэ хуульдаа энэ алагчлах уу, хэнийг. Тийм ээ. Сэтгэцийн эрүүл мэндийн төвд хэвтүүлэх үү, үгүй юу гэдгийг чинь бас хуулиар нарийн зааж өгөөгүй гэдэг ийм дүгнэлт гарч ирж байна.

Тэгэхээр хэд хэдэн хууль дээр зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ чиглэсэн энэ хууль дээр өөрчлөлт оруулах ийм зөвлөмжийг олон улсын байгууллагаас өгсөн байдаг юм байна.

Тэгээд сая Ц.Мөнх-Оргил гишүүн хэллээ. Тийм ээ. Үнэхээр бид хэдийгээр өнөөдөр хэрэгжиж байгаа хуульдаа бид хяналт тавья, ажлын хэсэг байгуулаад ажиллая гэдэг ийм санал гараад ажилладаг боловчиг олон улсын хүрээнд бид хүлээсэн үүргээ хэр биелүүлж байгаа юм.

Магадгүй төсөл, хөтөлбөрүүдээс энэ байгууллагууд маань амжилттайгаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээд иргэддээ хүрсэн үйлчилгээ үзүүлж байгаа юм бэ гэдэг дээр нэг ажлын хэсэг байгуулаад ажиллах таны саналыг би дэмжиж байна.

Энэ ажлын хэсэг байгуулах саналыг гаргамаар байна.

Өнөөдөр төрийн бус байгууллагууд маань тодорхой хэмжээнд хангалттай ажиллаж байгаа боловчиг өгдөг мөнгө нь гэдэг юм уу, зарцуулдаг

төсөв нь хязгаарлагдмал байдаг учраас хүрсэн хүүхдүүддээ үйлчилж чаддаггүй.

Өнөөдөр төр, хувийн хамтын ажиллагаа яг хөгжлийн бэрхшээлтэй энэ нь асаргаа шаардлагатай хүүхдүүддээ орхигдуулаад байдаг энэ хамтын ажиллагааг бид улам бүр нэгтгэх, зангидах шаардлага байгаа учраас би ийм саналыг гаргамаар байна.

Өнөөдөр бид ингээд төсөв мөнгө нэмүүлж байгаад бид ингээд асаргаанд байгаа хүүхдүүдийнхээ хувьсах зардлыг нэмдэг юм уу, нэмээд өгөөч ээ гэдэг энэ хүсэлт тавьсан боловч тодорхой хэмжээнд боломжгүй гэдэг ийм зүйл заалтыг хэлж байна. Дараагийн шатдаа гээд.

Тэгэхээр энэ бүхэн дээр яг ажлын хэсэг гаргаад ажиллая. Ер нь хүртээмжтэй байдал Монгол Улсад байдаггүй гэдгийг хүн болгон хүлээн зөвшөөрдөг боловч яг энэ рүү чиглэсэн ажил дутагдалтай байгаа. Хэдийгээр.../минут дуусав/

П.Анужин: Б.Жаргалмаа гишүүн үг хэллээ. Дамбын Батлут гишүүн асуулт асууна.

Д.Батлут: Өнөөдөр маш чухал асуудал яригдаж байна.

Бид ер нь хаа хаанаа л их сайн анзааргатай мэдээ мэдээлэлтэй байж нэгдсэн ойлголттой болж явахгүй болохгүй юм байна гэж бодож байна.

Зөвхөн шүүх хяналтын байгууллага гэхгүйгээр төрийн биш бүхий л шатын байгууллагууд яг үүнтэй холбоотой асуудал дээр онцгой анхаардаг байх ёстой юм байна гэж.

Тэгээд яах вэ, Монгол Улсын үндсэн хуулийн 10 дугаар зүйлд заасан тэр Монгол Улсын олон улсын гэрээ соёрхон баталсан буюу нэгдэн орсон хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжтой нэгэн адил үечилнэ ээ гээд заачихсан байна.

Тэгэхээр мэдээж энэ гэрээ конвенц, дотооддоо баталж байгаа хууль, эрх зүйн орчин тийм нэгдмэл байх ёстой. Тийм ээ. Ямар нэгэн тийм зөрүү байхгүйгээр хуулийн салаа үзүүр байхгүй байх ёстой гэж харж байгаа юм.

Өнөөдөр Монгол Улсад 294 энэ олон талт олон улсын гэрээ соёрхон баталчихсан байна.

Энэ дотор одоо яг хэрэглэгдэж байгаа, Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн орчинтой зөрчилдөж байгаа тийм хууль байна уу? Энэ талаар ер нь судалж үзсэн зүйл байгаа юу?

Тэгвэл хууль зөрчилдөж байгаа нөхцөл байдалд бид аль эрх зүйн орчноо барьж ажиллах вэ? Эсвэл энэ олон улсынхаа гэрээ, конвенцоос гарах ёстой юм уу?

Би тань таны түрүүний тайлбарлаж байгааг сонсож байгаад жишээлбэл Япон Улс гээд. Тийм ээ. Ямар нэгэн гэрээ хэлцэл олон улсын гэрээ конвенцод орох гэж байгаад хууль эрх зүйн орчноо оруулж судлаад хэрвээ шаардлага хангаагүй, болоогүй, цаг нь болоогүй орохгүй ээ гээд хойш тавьдаг гэж байна.

Тэгэхээр бид нарт бас тийм боломж, шаардлага байгаа шүү дээ. Тэгэхэд одоо бид магадгүй үүнийг төдийлөн сайн судлаагүй, хараагүйгээсээ болоод ийм алдаа гарсан зүйл байна уу? Хэд. Тэгвэл бид яах юм? Цаашлаад.

Хууль орчноо сайжруулах боломж төсөл нь өнөөгийн цаг хугацаанд байгаа юу, үгүй юу? Байхгүй бол энэ гэрээ, конвенцоос гарах ёстой юу гэдэг дээр хариулт авъя.

Хоёрдугаарт нь, өнгөрсөн 5 жилийн хугацаанд Монгол Улсын анхан шатын шүүхээр 421 мянган хэрэг шийтгэгдсэн байна л даа.

Тэгэхээр бид зүгээр энэ хууль эрх зүйн орчинд ижил тэгш үйлчилж байгаа учраас бид гаднын энэ гэрээ гадаад улстай байгуулсан энэ гэрээ конвенцыг энэ хууль эрх зүйн орчинд ашигласан тийм жишээнүүд байна уу? Бид магадгүй мэдээж цаана нь холбогдож байгаа асуудлууд дотроо иргэн талдаа гарч байсан ийм үр дүнгүүд байгаа юу?

Тэгэхээр бид ер нь мэдээж энэ асуудлуудыг шийдэх хэрэгтэй. Шийдэхийн тулд нийгмийн хэмжээний маш том соён гэгээрлийн ажлыг хийх зайлшгүй шаардлага байна гэж харж байна л даа. Энэ чухал зүйл дээр анхаарах ёстой юм байна гэж.

Ингэж байж энэ гэрээ конвенц, олон улсын олон талт гэрээ конвенцтой холбоотой дотоод хууль эрх зүйн орчинтой зөрчлүүдийг алга болгохоос авхуулаад, мөн олон улсын түвшинд нийцсэн тийм хүлээн зөвшөөрөгдөх нөхцөл, хууль эрх зүйн орчноо бүрдүүлэх, цаашлаад ашиглах, иргэндээ ээлтэй тийм нийгмийг бий болгоход томоохон чухал ахицууд гарна гэж харж байгаа.

Энэ хоёр асуулт дээр хариулт авъя.

Тэгээд ер нь цаашлаад би бодож байна. Ц.Мөнх-Оргил гишүүний хэлж

байгаа ажлын хэсэг дээр орж ажиллах хүсэлт байна.

Мөн үүнийг маш өндөр түвшинд гаргаж олон түвшинд хэлж ярьж тэр гүйцэтгэл, тайлантай холбоотой, цаанаас ирж байгаа зөвлөмжтэй холбоотой асуудлыг, тэр зөвлөмжийн дагуу олон шат шат дараалсан арга хэмжээнүүдийг авдаг.

Мөн тэр сан үүсгэх гээд олон зөрчлүүдийг алга болгохын төлөө ажиллах зайлшгүй шаардлага байна гэж харж байгаа гэдгээ давхар хэлье. Баярлалаа.

П.Анужин: Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуултад хариулья.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн тэр гэрээний үүргүүд манай хууль тогтоомжид сууж уу, суугаагүй суулгах хэрэгтэй. Суучихсан мөртлөө нөгөө олон улсын гэрээ конвенцынхоо заалттай зөрчилдчихсэн байвал. Тийм тохиолдлууд байгаа л даа. Зөндөө байгаа юм.

Бид энэ 30 конвенцоороо нэг бүрчлэн гаргаж байна шүү дээ. Сая жишээ нь, тэр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах конвенцын заалтыг. Маш тодорхой жишээ хэллээ шүү дээ. Тийм ээ. Болохгүй шүү гээд байхад нь бүр болно шүү гээд эрх өгчхөж байна шүү дээ. Гэх мэтийн. Бид залруулна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, нөгөө гэрээний заалтууд чинь үндсэндээ хоёр өөр төрөл юм байгаа байхгүй юу. Нэг нь шууд үйлчилчихдэг заалтууд байгаа юм. Гэрээнд нэгдээд л орчихоор шууд үйлчилнэ.

Гэтэл зарим конвенцууд дээр хэлчихсэн байгаа байхгүй юу. Энэ гэрээний энэ заалтыг дотоодын хууль тогтоомждоо заавал суулгана шүү гээд.

Жишээ нь, юу гэдэг юм хар тамхитай тэмцэх ч байдаг юм уу, үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх эсрэг конвенц байлаа шүү дээ. Тийм ээ. Тэр дээр юу гээд биччих вэ гэхээр хүн наймаалах гэмт хэргийг заавал Эрүүгийн хуульдаа онц ноцтой гэмт хэрэг болгож суулгана шүү гэж үүрэг хүлээчхэж байгаа байхгүй юу.

Тэгээд тэр нь биелээгүй бид нөгөө конвенцын заалтаа биелүүлээгүй нь ойлгомжтой.

Яг үг үсгээрээ зөрчилдчихсэн заалтууд гарна.

Тэгэхээр бид хууль батлахдаа нэг заалт хийгээд байдаг шүү дээ. Тийм ээ. Энэ хуулийн заалт юунууд нь Монгол Улсын нэгдэж орсон олон улсын гэрээ конвенцын заалт зөрчилдөх юм олон улсын гэрээ конвенцын заалт хүчин төгөлдөр шүү гэж. Өөрөөр хэлбэл тэр заалт нь үйлчлэх ёстой байхгүй юу.

Тэгэхээр нөгөө шүүгч жишээ нь хэлэх нь байна шүү дээ. Конвенцын заалтаар явна. Яагаад гэвэл Хөдөлмөрийн хуулийн тэдийн тэд дээр 4.3 дээр олон улсын гэрээний заалт үйлчилнэ ээ гээд биччихсэн байна гээд явах ёстой.

Гэтэл нөгөө шүүгчдэдээ. Одоо бидний буруу л даа. Шүүгчдэдээ бид Монгол Улсын нэгдэж орсон олон улсын хөдөлмөрийн байгууллагын 8 суурь конвенц байгаа байхгүй юу. Бүр суурь. Энэ бол ерөөсөө бүр заавал элсэх ёстой. Одоо тэр албадан хөдөлмөр эрхлэх, хөдөлмөрийн насны хязгаар мязгаар гээд.

Тийм ээ. Үйлдвэрчний эвлэл байгуулах эрх гээд.

Үүнийг жишээ нь, одоо яг тэр хөдөлмөрийн маргаан шийдвэрлэж байгаа шүүгч нарт бид монгол хэл дээр нь, тэгээд тайлбартай нь хүргэж өгөх ёстой байхгүй юу. Гар дээр нь тавих ёстой.

Тэгээд юу гэдэг юм, үйлдвэрчний эвлэл, Засгийн газар хоёрын ч юм уу, хоёр үйлдвэрчний эвлэлийн хооронд маргаан гарлаа гэхэд шүүгч Хөдөлмөрийн хууль юм уу, Үйлдвэрчний эвлэлийн хуульд тэр тухай байхгүй байсан бол конвенцынхоо заалтыг хараад энэ чинь ингэж байна, ингэж шийдэх ёстой юм байна гээд шийдэж байх ёстой байгаа юм.

Тэгж байж бид нэг талаас үүргээ биелүүлнэ. Нөгөө талаас бидний ярьдаг нөгөө хүний эрхийг хамгаалах процесс чинь жинхэнэ утгаараа юугаа олж байгаа байхгүй юу. Механик процессоо олж байгаа байхгүй юу. Тийм ээ. Аргачлалаа олж байгаа юм. Тэрийг хийх ёстой юм байгаа юм.

Тэгээд одоо энэ ажил хийгдээд дууссаны дараа бид юу гэж бодож байгаа вэ гэхээр Шүүхийн ерөнхий зөвлөл, Засгийн газартай хамтраад сэдэвчлээд энэ конвенцуудаар бүр ийм цуврал сургалтууд хийх ёстой юм байна. Шүүгч нарт. Эхний ээлжинд шүүгч, прокурорундад.

Тэр 421 мянган хэрэг шийдэхэд энэ олон улсын гэрээ конвенцыг ашигласан юм байна уу гэвэл би буруу сонсоогүй бол 4 билүү, 5 хэрэг дээр ашигласан, ер нь ашиглах тийм практик эхэлж байгаа юм билээ. Сурч эхэлж байгаа юм байна лээ.

Манай хуульд чинь Монгол Улсын нэгдэн орсон, тэгээд төрийн мэдээлэлд албан ёсоор хэвлэгдсэн эхээр л нөгөө шүүгчийн хэрэг шийдэх ёстой шүү дээ.

Тэгэхээр бид нэгдүгээрт, бүх конвенцуудаа төрийн мэдээлэлд.../минут дуусав/

П.Анужин: Баярлалаа. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Энэ олон улсын конвенц гэдэг бол том ойлголт.

Ер нь дэлхийн хамтын нийгэмлэг гэнэ үү, бүс нутгийн интеграц гэнэ үү, бид нэг гэр бүл шүү дээ. Дэлхийн нэг гэр бүл. Тэрийгээ ойлгож хандахгүй бол манай диктаторууд чинь ер нь улам л диктатор юм шиг болчих гээд л байдаг.

Тэгээд энэ дээр чинь дэлхий өөрөө тухайн улс орны асуудал руу нь орохгүй мөртлөө нийтлэг жишгийг тогтоож тойруу утгаар тэр ард иргэдийг хамгаалж байгаа л нэг хэлбэр л дээ.

Тэгээд би иргэн Ламжав гуайтай дээр. Би ёстой нэг жуниор тэмцэгч төдий амьтан байхад л ярьж байсан юм.

Та яагаад цэцэд овоо ингээд юмаа ялаад байна гэсэн. Олон улсын гэрээ конвенцуудыг л би их ашигладаг даа гээд. Тэгээд би их унших дуртай. Тэгээд манай хүний эрхийн комиссын тайлангууд аягүй сайн. Тэр дээр би юм ашиглахыг хичээдэг. Тэгээд энэ их чухал юм орж ирсэн байна.

Ц.Мөнх-Оргил гишүүнд талархаж байна.

Нэгдүгээрт, ер нь хүний эрхийн конвенцын тэр хоёрдугаар хуудсан дээр байдаг юм. Ерөөсөө хүний эрхийг хэн зөрчдөг вэ гэдэг асуултыг их тодорхой тавьсан байдаг. Шийдвэр гаргагч гэж. Бүр **Decision Maker** гэж үг байгаа шүү дээ.

Тэгэхээр манайд бол яг хүний эрхийг шийдвэр гаргагч нар л цөм будаа болгож байгаа. Айлаар очоод тарааж байгаа хүн зүгээр эрүүгийн гэмт хэрэгтэн. Тэр тэр хариуцлагатай өөр хууль.

Тэгэхээр шийдвэр гаргагч дарга нартай энэ их холбоотой байдаг. Тэгээд яах вэ азаар тэр нөгөө шүд нь байхгүй учраас энэ Хүний эрхийн комиссынхон ч байна уу, холбогдох хүмүүс нь тайлангаас цаашаа хэтэрдэггүй учраас мань мэтэд их боломж өгч энэ түмэн олонд хайрлагдах тийм алтан боломж надад өгсөн. Их баярлаж явдаг.

Тэгэхээр миний нэгдүгээр асуулт. Хүний эрхийн энэ олон конвенцуудыг хэрэгжүүлэхийн тулд. Одоо манайх чинь Үндсэн хууль дээр хүний эрхийг тунхагласан. Эрхээ ингээд тунхаглаад байгаа.

Тэгэхээр чи эрхтэй шүү. Эрхээ гоё шүү гээд байгаа боловч эрхээ яаж хамгаалах вэ, хаана гомдол гаргах вэ гэдэг дээр **Dispatch Settlement**-тэй механизм ерөөсөө байдаггүй.

Би олон жил ярьдаг, байнга ярьдаг. Бизнес эрхлэгчид энд орж байгаа шүү. Заавал хүний эрх гэхээр малчин, тариачин, үйлдвэрчний хүн яриагүй. Бизнесменүүд хамгийн их орно. Бүр нарийн яривал. Эдний маргаан таслах тэр платформыг байгуулах тал дээр бодсон санасан юм байдаг болов уу?

Яагаад гэвэл шүүхэд ханд л гэж байгаа юм. Шүүхэд өнөөдөр мөнгөтэй, албан тушаалтай, том гаруудын л ажил болчих гээд байдаг.

Цаг хугацаа явдаг, мөнгө явдаг, өмгөөлөл явдаг. Нэгдүгээр ажил.

Хоёрдугаар ажил. Би их олон жил мөрөөддөг юм. Үйлдвэрчинд байсаар байгаад.

99 дүгээр конвенц л манайд үгүй ээ мөн хэрэгтэй. Хэрэггүй конвенц их орж ирнэ. Саяхан яг энд парламент дээр озоны давхаргыг хамгаалах билүү нэг конвенц орж ирсэн.

Бүр сайн уншаад үзсэн чинь хөргөгч мөргөгчийг оруулж ирэхэд өндөр татвар тавина л гэсэн юм байгаа шүү дээ. Пероны газ оруулж ирэхгүй. Америк нэгдээгүй, тэрэнд. Хятад нэгдээгүй. Тэгсэн тэрэнд манайхан уралдаад нэгдэж байгаа юм.

Зүгээр би дотроо боддог юм. Энэ яаманд нэг хэдэн төгрөгийн төсөв хэрэгжүүлж байгаа юм байх. Төсөл хэрэгжүүлж байгаа юм байх. Юмаа авчихсан юм байх даа зайлуул л гэж бодсон. Би эсэргүүцээд бараагүй.

Тэгэхэд чинь яг 99 дүгээр конвенц ерөөсөө энэ цалин хөлсний конвенц их чухал конвенц санагддаг юм. Тэр одоо хүртэл байдаггүй юм. Зүгээр сонирхоод асуучихъя. Хоёрдугаар асуулт.

Гуравдугаар асуулт. Энэ тодорхойлолт сайн байна. Энэ удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх бодитой арга хэмжээ авах гэж байгаа юм шүү.

Дүр эсгэсэн өнөөдрийн байдалтай байж болохгүй ээ гээд бүр эдийн засаг,

нийгмийн хорооноос өгсөн зөвлөмжүүд дээр их чухал чухал зүйлүүд заасан байна.

Уул уурхай бол та нарыг чинь зүгээр дээрэлхэж байна даа. Уул уурхай, улс төр хоёр чинь мафи болчихсон. Энэ ядарсан хүмүүсийг чинь зүгээр дарамт.../минут дуусав/

П.Анужин: С.Ганбаатар гишүүнд нэмэлт 1 минут өгье.

С.Ганбаатар: Тийм. Тэгээд энэ дээр маш чухал зүйлүүд бас байна.

Цаашид авах арга хэмжээний тухай санал дээр бүр удаа дараа та нар зөрчиж байгаа юм гэсэн хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх. Тэр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт байхгүй. Зүгээр л дүр эсгээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаална л гээд заачихсан.

Ямар ч хэрэгжилт байхгүй.

Төрийн байгууллагууд хэрхэн хэрэгжүүлж байгааг Улсын Их Хурал, Хууль зүйн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хорооны хамтарсан шалгалтыг төрийн бус байгууллагуудын хамт зохион байгуулахыг удаа дараа энэ дээр зөвлөмж дээрээ бичсэн байна.

Тэгээд уул уурхай дээр өртөж байгаа улсуудыг нүүлгэхдээ. Албадан нүүлгэх гэж байгаа юм шүү. Эрсдэлтэй тулгарч байгаа. Үүнийгээ одоо та нар яг хамгаалсан чиглэлийн хууль тогтоомж байхгүй байна л гээд байгаа юм.

Нөгөөдүүлийг манай Уул уурхайн яам. Би 20 жил хийсэн ажил. Аз жаргалын садаа гэж.../минут дуусав/

П.Анужин: Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуултад хариулъя.

Ц.Мөнх-Оргил: Ер нь энэ хүний эрхийн үүрэг, хүний эрх тусдаа хоёр ялгаатай л даа.

Нэг хэсэг нь болохоор өөрөө ингээд төр заавал хангах ёстой заалтууд байгаа юм. Төр өөрөө бүр хариуцлага, заавал нөгөө хэрэгжилтийн үүрэгтэй. Жишээ нь, жагсаал цуглаан зохион байгуулах эрхийг төр өөрөө боомилохгүй байх ёстой. Эсвэл сонгууль зохион байгуулах ёстой. Шударга зохион байгуулах ёстой. Эсвэл эвлэлдэн нэгдэх эрхийг хангах ёстой гээд ингээд төрөөс садаа болохгүй байх ёстой.

Нөгөө нэг хэсэг. Ялангуяа манай Байнгын хороотой холбоотой юмнууд нь төр өөрөөсөө хамаарч байгаа өөрийнхөө хүчин чадалд байгаа бүхий л хүчин чадлыг л гаргах ёстой. Жишээ нь.

Гэхдээ тэр нь хангалтгүй байгаад үр дүн гараагүй, хүссэн хүлээсэн үр дүн гараагүй байж болно.

Жишээ нь, жагсаал цуглаан дээр заавал үр дүн гаргах ёстой. Тийм ээ. **The obligation of result**_[үр дүнгийн амлалт] гэж. Нөгөөдөх нь болохоор хүчин чармайлт гаргах ёстой үүрэг гэж. **The obligation to report.**

Тэр нь юу гэдэг юм аюулгүй орчинд амьдруулах бүх л хүчин чадлаа дайчилсан байх ёстой.

Юу гэдэг юм байгаль орчныг хамгаалах бүх л хүчин чадлаа гаргах ёстой гээд. Ингээд нөгөө үүргүүд нь ялгаатай байхгүй юу. Конвенц конвенцоороо ялгаатай.

Тэгэхээр бид үүнийг нь тэгж ялгаж харах ёстой болчихоод байгаа байхгүй юу.

Түүнээс биш юу гэдэг юм ингэчихсэн юм чинь заавал 100 хувь бэлдсэн байх ёстой. Хүн болгон ажилтай байх ёстой, хүн болгон орон байртай байх ёстой. Конвенцын заалт хэрэгжээгүй байна гэж хэлж болохгүй л дээ.

Тэр чинь нөгөө улс улсынх нь юуг харж өөрөөсөө шалтгаалж байгаа юмаа хийж байна уу л гэдэг гол асуудал байгаа байхгүй юу.

Тэр маргаан таслах асуудал дээр мэдээж аль ч улс шүүхийн асуудал байгаа. Шүүх дээрээ л очно. Бизнес нь ч байна уу, хувь хүн ч байна уу шүүхээ сайжруулах асуудал дараагийн асуудал.

Энэ дээр олон жил яригдаж байгаа. Одоо бид Улсын Их Хуралд хэсэг гишүүд цэцийн тухай хуулийг өргөн барья гэж бодож байгаа юм.

Түүн дээр Үндсэн хуулиар баталгаажуулж олгосон үндсэн эрхээ эдлэхэд нь садаа болсон тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэдэг ийм механизм байгаа юм.

Энэ бол нөгөө үндсэн эрхийн гомдол гэж. **A constitutional complaint** гэж. Тэр нь яг өөртөө тохиолдсон өөрийнх нь эрх зөрчигдсэн тохиолдолд гомдол гаргах асуудал.

Манайх чинь одоо тийм гомдол гаргах эрх нь байхгүй шүү дээ. Улсын Их Хурлын баталсан өөрт нь огт хамаагүй байсан ч гэсэн Улсын Их Хуралд баталсан хууль нь л Үндсэн хуультай зөрчилдсөн байх юм бол надаа хамаагүй.

Гэхдээ энэ хууль Үндсэн хууль зөрччихлөө гэдэг гомдол гаргах л эрх нь байгаа байхгүй юу. Нөгөө **abstract review** буюу өөрт хамаагүй асуудлаар гомдол гаргах эрхтэй.

Өөрт нь хамаатай асуудлаар гомдол гаргах эрх нь байхгүй байгаа байхгүй юу. Гэхдээ энэ өөрөө их зовлонтой асуудал л даа. Жишээ нь, шүүхийн шийдвэр яах юм гэдэг асуудал гарч ирж байгаа юм. Тийм ээ.

Зарим шүүхийн шийдвэр нь энэ хяналтад орох ёстой, зарим нь орох ёсгүй.

Үүнийг нь салгаж өгөх эрхтэй болно. Засгийн газрын зарим журам орно. Үарим нь орохгүй гээд. Энэ асуудал орж ирнэ.

Тэгээд энэ хуулийг хэрвээ бид батлаад цэц үндсэн эрхийн гомдол хүлээж авч хэлэлцдэг болчих юм бол манай энэ эрх зүйн системд их том хувьсгалын шинж чанартай өөрчлөлт гарна.

Тэгэхдээ үүнийг хийх үү хийхгүй юу гэдгээ хэдүүлээ ярих ёстой байгаа юм. Тэгээд гол юм түрүүн Д.Батлут гишүүн хөндөөд хэлчихлээ.

Бид хэрэгжүүлэх бололцоо өнөөдөртөө байхгүй байгаа бол оромгүй л байгаа байхгүй юу. Тийм ээ. Оромгүй л байгаа юм. Түүнээс 5 жилийн дараа бололцоотой болчихно. Тэр болтлоо.../минут дуусав/

П.Анужин: Цэндийн Мөнх-Оргил гишүүн хариултаа гүйцээж хариулъя.

Ц.Мөнх-Оргил: Түүнээс биш одоо юу гэдэг юм уг нь сайн конвенц юм. Хэрэгжүүлчихвэл зүгээр юм. Тэгэхдээ яг

бололцоо нь 5, 10 жилийн дараа л гарах юм байна.

Тэр болтол хэдүүлээ ороод байж байя гэдэг л хандлагаасаа бид салмаар байгаа байхгүй юу. Тийм ээ.

Яг бид бололцоо гүйцлээ, бүрдлээ. Хэн нэгэн хүнд чичлүүлэхгүйгээр бид энэ гэрээ, конвенцоо хэрэгжүүлчих юм байна гэсэн итгэл үнэмшилтэй болсон хойноо л нэгдэж ормоор байгаа юм.

Манай Үндсэн хуульд чинь тэр нэгдэж орсон гэрээ, конвенц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр гэхээсээ гадна олон улсын үүргээ бид үнэнч шударгаар биелүүлнэ гээд Үндсэн хуулийн заалттай шүү дээ. Тэр чинь аягүй том заалт байхгүй юу.

Хоёр талын өөр улстай гэрээ байгуулсан байна уу, олон улсын байгууллагын өмнө хүлээсэн байна уу үүрэг хүлээсэн л бол энэ У.Хүрэлсүхийн Засгийн газар уу, Н.Алтанхуягийн Засгийн газар уу, Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар уу, ерөөсөө хамаагүй шүү дээ. Монгол Улс бүхэлдээ л хүлээчхэж байгаа учраас тэр Засгийн газар үл харгалзаад, нам үл харгалзаад нийтдээ дараа дараагийн Монголчууд энэ үүргээ хүлээж байгаа учраас бид их тийм анхааралтай хандмаар байгаа байхгүй юу.

Энэ дээр бид ерөөсөө Их Хурал нэг л тийм, юу гэдэг юм би гомдол мэдүүлэх юм уу, хаашаа юм. Бид ерөөсөө тэгсхийгээд л өө энэ чухал юм байна, чухал юм байна гээд л орчхоод байгаа байхгүй юу.

Сая С.Ганбаатар гишүүн тэр озаны давхаргыг хэлж байна шүү дээ. Тийм ээ. Яах вэ, энэ хоёр талтай л даа.

Бид олон улсын хамтын нийгэмлэгийн хүчин чармайлтад зүтгэж байх ёстой, хувь нэмэр оруулж байх ёстой. Гэхдээ өөрийнхөө эрх эрхийг бас харгалзаж байх ёстой.

Энэ хүчин чадал нь байна уу, үгүй юу гэдгийг харгалзаж байх ёстой байгаа юм. Тэгээд хууль тогтоомж нь нийцэж байна уу, үгүй юу.

Тэгээд бүх юм бэлэн болчихлоо гэхээр үүнийг яг хэрэгжүүлэх бид нарт мөнгө нь байлаа гэхэд хүн нь байна уу, нөөц нь байна уу. Тийм ээ. Энэ бүгдийг харж л бид гэрээ, конвенцдоо нэгдэж орж баймаар юм билээ. Баярлалаа.

Ц.Анужин: Цэндийн Мөнх-Оргил гишүүнд баярлалаа.

Маш чухал асуудлыг өөрийнхөө санаачилгаар энэ маш чухал ажлыг ахалж өнөөдөр тайлангаа Та бидэнд тавилаа.

Чадах, чадахгүй юм юм руу үсэрч орж тэгээд хэрэгжилтээ эргээд хэн нь ч хардаггүй. Тэгээд эргээд олон улсын өмнө эвгүй байдалд ордог ийм чухал асуудлыг өнөөдөр тавьж.

Тэгээд холбогдох Байнгын хороодууд эдгээр асуудалд хэрхэн хандах тухай маш чухал асуудлыг хэлж, гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зүгээр нэмээд хэлэхэд Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд бас Ц.Мөнх-Оргил гишүүний тайлантай холбогдуулж өөрчлөлт оруулбал бас зүгээр юм уу гэсэн санал бодогдож байна.

Өмнө нь жишээлбэл Байнгын хороон дээр тайлан хэлэлцэх дэгт юу байсан бэ гэхээр Эмэгтэйчүүдийг

алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын тайланг сонсох гээд л жишээлбэл байсан.

Тэгэхдээ хуралдааны дэг өөрчлөгдөөд л одоо энэ асуудлыг аваад хаячихсан байхгүй юу.

Тэгэхээр эдгээр чухал конвенцуудыг харьяа мэргэжлийн Байнгын хороо хэлэлцдэг байх гэсэн дэгийн тухай хуульд тодорхой өөрчлөлт оруулаад ирвэл хэлэлцээд л явчихна.

Тэгэхээр эдгээр энэ маш чухал асуудлууд бас хуумгай хандаж энэ хууль дүрмээсээ авч хаяад байгаа ч гэсэн бид цаашдаа анхаарах ёстой юм уу гэсэн ийм санал байна.

Тэгээд эдгээр Ц.Мөнх-Оргил гишүүний хэлсэн, манай харьяа Байнгын хороотой холбоотой асуудлууд дээр цаашдаа анхаарч ажиллаж, энэ гишүүд ажлын хэсэг гаргах саналуудыг гаргаж байна.

Үүнийг хэлэлцэж энэ тал дээр Байнгын хороо хэлэлцэх нь зүйтэй гэсэн ийм саналтай байна. Баярлалаа. Гишүүддээ.

Монгол Улсын олон талт олон улсын гэрээ, гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж дууслаа.

Хуралдаанд оролцсон ажлын хэсгийн гишүүд болон энэ ажлыг ахалсан Цэндийн Мөнх-Оргил гишүүнд баярлалаа.

Хэлэлцэх асуудлынхаа гуравдугаарт орёе.

**Гурав. “Сонголын тов тогтоох, сонгол даргалагчийг сонгох тухай”
Байнгын хорооны тогтоолын төсөл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Г.Амартүвшин, Т.Аубакир, Д.Батлут, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Н.Наранбаатар, Д.Өнөрболор, Б.Саранчимэг, Т.Энхтүвшин нарын 9 гишүүнээс Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонголыг зохион байгуулах тухай хүсэлтээ Улсын Их Хурлын даргад ирүүлсэн байгаа.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 25.3-д холбогдох Байнгын хороо зохион байгуулна гэсний дагуу өнөөдрийн хуралдаанаар бид сонголын тов болон сонгол даргалагчийг томилох асуудлыг хэлэлцэж байгаа.

Хяналтын сонголын гол агуулга нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7.1-д заасан хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрх, 7.3-д заасан хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, хувийн мэдээлэл, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах асуудлыг тусгасан байгаа.

Нийтийн сонголын тухай хуулийн 31.5 дахь хэсэгт заасны дагуу сонголын бэлтгэх хугацаа нь 14 хоногоос доошгүй байна гэж заасан байгаа.

Тийм учраас энэ өдрөөс хойш тооцоход хамгийн боломжит хугацаа нь 7 сарын 03-ны өдөр буюу нэг дэх өдөр таарч байгаа юм. Гишүүд ээ.

Сонголыг даргалах тал дээр гишүүд саналаа өгч болно.

Сонголын тогтоолыг уншиж танилцуулъя, Та бүхэндээ.

“Хяналтын сонголын тов тогтоох сонгол даргалагчийг сонгох тухай”.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14, Монгол Улсын хяналт шалгалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.4, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.1, 119 дүгээр зүйлийн 119.1, Нийтийн сонголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7.1, 7.3 дахь хэсэгт заасан эрхийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонгол явуулах хугацааг 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрөөр товлосугай.

2.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмааг сонгосугай.

3.Сонгол зохион байгуулах бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын Тамгын газарт даалгасугай.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин гэсэн ийм тогтоолын төслийг Та бүхэндээ танилцуулж байна.

Хурал даргалах тал дээр гишүүд нэрсээ өгч болно. Байнгын хорооныхон бид хэлэлцэж тохироод Бадарчийн Жаргалмаа гишүүнийг томилъё гэсэн саналыг оруулж байгаа.

Саналтай гишүүд байна уу? Саналаа хураачихья.

“Сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя

гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал 60.0 хувиар дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудал үүгээр өндөрлөж байна.

Байнгын хорооныхоо хуралд идэвхтэй оролцсон, саналаа хэлсэн эрхэм гишүүд Та бүхэндээ баярлалаа.

Хуралдаан 2 цаг 34 минут үргэлжилж, 13 цаг 57 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД